

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-7</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>8-47</i>
<hr/>	
1. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай	8-19
2. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	19-21
3. Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	21-47

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 07 дугаар сарын 09-ний  
өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 08 цаг 53 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Номтойбаяр, Л.Гантөмөр, Э.Одбаяр.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Д.Энхтүвшин, А.Ариунзаяа нар оролцов.

**Нэг. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Б.Баасандорж оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Б.Баасандоржийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир 09 цаг 08 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Пүрэвдорж, Б.Батбаатар, Т.Доржханд нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Дамдины Энхбатыг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 2  
Бүгд: 19  
89.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

**Ц.Сандаг-Очир:** “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 2  
Бүгд: 19  
89.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэн яаралтай хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Засгийн

газрын референт О.Дөлгөөнтуул, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохихсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар асуулт асууж, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

*Байнгын хорооны хуралдаан 09 цаг 45 минутаас 10 цаг 32 минут хүртэл түр завсарлав.*

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хуулийн төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг танилцуулав.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Батбаатар, С.Зулпхар, А.Ариунтуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Пүрэвдорж, Т.Доржханд, Б.Батбаатар, С.Зулпхар, О.Номинчимэг, Э.Болормаа, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-д заасны дагуу санал хураалтыг явуулав.*

**Ц.Сандаг-Очир:** 1.Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 16 минут үргэлжилж, 25 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 88.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 56 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ц.САНДАГ-ОЧИР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 08 цаг 53 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энх-Амгалан:** Энэ аппарат жаахан санал хураахад хүндрэлтэй байгаа учраас эхлээд ирцээ яагаадахъя, ирцдээ ороодохъё гар өргөөд тэгэх үү? Тийм. Гар өргөөд явчихъя. Угаасаа эхний хуралдаан дандаа гар өргөж явсан учраас түүнийгээ үргэлжлүүлээд.

Ингээд ирсэн гишүүдийн ихэнх нь ирцэд орсон тул Байнгын хорооны өнөөдрийн хуралдааныг нээе.

Өнөөдрийн Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 24 оны 7 сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байгаа юм байна.

1-д нь, Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл. Засгийн газрын өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх,

2-т нь, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох чөлөөлөх тухай асуудал,

3-д нь, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Амарбаясгалан дарга.

**Д.Амарбаясгалан:** Яах вэ, өчигдөр нөгөө Засгийн газраас бас цаг асуугаад Төрийн байгуулалтын байнгын хороо хэдэн цагт хуралдах вэ гээд асуухад нь багцаа цаг гээд 10 цаг гээд өгчихсөн юм. Тэгэхээр нөгөө Ерөнхий сайд арай бэлтгэлээ хангаж амжаагүй байх шиг байна. Тэгэхээр хэлэлцэх асуудлынх нь дараалалд өөрчлөлт оруулаад, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг 3 дугаарт нь хэлэлцэхээр оруулаад, эхний 2 асуудлаа хэлэлцээд явж байхад бэлэн болгоод ороод ирэх болов уу гэж бодож байна. Тэгэхээр дараалалд өөрчлөлт оруулъя.

**Л.Энх-Амгалан:** Амарбаясгалан даргаас, гишүүнээс горимын санал горимын санал гаргасан тул горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор.

Олонх нь дэмжсэн тул хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт орсон учраас 2 буюу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай асуудал юм байна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөхтэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан дарга танилцуулга хийх юм байна.

**Д.Амарбаясгалан:** Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосноор УИХ томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилуулахаар санал оруулж байна.

Барсүрэнгийн Баасандорж нь 1979 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.

Б.Баасандорж нь 1987-1997 онд нийслэлийн 5 дугаар дунд сургуулийг, 1997-2001 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2009-2011 онд АНУ-ын Калифорнигийн Олон улсын их сургуулийг Бизнесийн удирдлагын мастерын зэрэгтэйгээр тус тус төгссөн.

2001-2002 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын туслах, 2002-2006 онд Улсын Их Хурлын Тамгын газар дахь Хуулийн хэлтсийн шинжээч, 2006-2008 онд Хууль зүйн байнгын хорооны референт, 2008-2009 онд Хууль зүйн байнгын хорооны зөвлөх, 2011-2013 онд Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, 2013-аас 15 онд Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга, 2015-аас 18 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, 2018-2020 онд УБЕГ-ын дарга, 2020-2022 онд ХЗДХЯ-ны ТНБД, 2022-оос 23 онд МХЕГ-ын дарга, 2023 оноос одоог хүртэл ЗГХЭГ-ын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргаар ажиллаж байна.

Б.Баасандорж нь төрийн албанд 23 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлж батлуулах чиглэлээр 16 жил, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 5 жил, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр 2 жил, үүнээс төрийн албаны удирдах албан тушаалд 15 жил тус тус ажилласан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх шаардлагыг бүрэн хангаж байгаа нэр дэвшигч болно.

Төрийн албанд гүйцэтгэх албан тушаалаас удирдах албан тушаал хүртэл шатлан дэвшиж ажилласан. Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай.

Хүний эрхийн салбар, нийтийн мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийг хангах, шүүхийн шинэтгэл, улсын бүртгэлийн шинэтгэлийн зэрэг хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулж байсан. Тухайлбал Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 126 гишүүнтэй парламент, хувь тэнцүүлсэн болон олонхын сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийн төслийг боловсруулах болон иргэд олон нийтэд хэлэлцүүлэх Засгийн газрын дэд ажлын хэсгийг ахалж ажилласан. Мөн төрийн захиргааны үйл ажиллагаа, төрийн үйлчилгээнд процесс суурьтай, оновчтой, үр дүнтэй засаглалыг бэхжүүлэх зорилгоор гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын хүрээнд процессын дахин инженерчлэлийг эхлүүлж, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар, эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, ирээдүйн загварыг гаргах ажлыг амжилттай хэрэгжүүлж ажилласан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилуулах саналыг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна. Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

**Л.Энх-Амгалан:** Амарбаясгалан даргад баярлалаа.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөхтэй холбогдуулан асуух

асуулттай гишүүд байна уу? Ганбаатар гишүүн, Сайнзориг гишүүн.

Ганбаатар гишүүний микрофон.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Баасандорж даргыг дэмжиж байна. Их Хурлын даргаас асуулт байна. Өмнөх парламент харж байхад бол энэ хууль өргөн барихдаа ялангуяа Баасандорж дарга бол их анхаарах хэрэгтэй. Яаралтай горимоор гэдэг юм уу эс үгүй бол нэг цаг үеийн асуудлуудыг тэр хуулиудын тухай хууль гээд байгаа. Тэмүүжин гишүүн санаачилж батлуулсан шиг санагдаж байна. Тэгэхдээ би тэр үед гишүүн байгаагүй л дээ. Түүнийг ерөөсөө баримталдаггүй юм, ерөөсөө баримталдаггүй. Тэгээд л бараг өчигдөр яригдаж байгаад л өнөөдөр хууль Их Хурлаар ороод ирдэг. Энэ чинь нийгмийн хэлэлцүүлэг хийгдэх ёстой, санал авах ёстой. Жишээлбэл, Ашигт малтмалын хууль гэхэд 3 удаагийн хэлэлцүүлгийг Их Хурал дээр бол олон нийтэд хийгдсэн. Тэгээд тэрийг их сайн баримтлах нь зөв байна аа гэж би бол үздэг. Тэгээд үүнийг их сайн баримтлах хэрэгтэй. Тэгэхгүй бол тэр ер нь бол тийм яаруу сандруу зүйл бол их олон буруу зүйлийг дагуулдаг шүү. Энэ дээр Баасандорж дарга яаж ажиллах вэ гэдгийг бас асууя.

2 дугаарт, Тогтохсүрэн дарга гол нь энэ ажлыг хийе гээд л явж байсан даа. Тогтохсүрэн дарга нь уул нь өнгөрсөн 4 жилд бүлэг маш сайн удирдсан. Ялангуяа хувийн хэвшил болоод эдийн засгийн асуудал дээр маш тийм зөв чиглэлтэй ажилладаг ийм хүн дээ. Тэгээд яасан юм бол? Ямар шалгуурт тэнцээгүй юм бол? Тэр хүн байсан бол их л олон зүйл дээр тийм зөв чиглэл гаргах болов уу гэж би бас дотроо бодож байх юм.

Ийм 2 асуултад асуултад хариулт авъя. Тодруулж болно, тийм ээ, дарга аа.

**Л.Энх-Амгалан:** Тийм, тэгээд тодруулж болно. Б

**Ж.Ганбаатар:** Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** 2 дахь асуултад Амарбаясгалан дарга хариулаад, эхний асуултад нь нэр дэвшигч хариулъя. Тийм.

Эхлээд Амарбаясгалан дарга хариулъя.

**Д.Амарбаясгалан:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт санал нэг байна. Засгийн газраас яаралтай горимоор олон асуудлыг өргөн барьж Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа.

Тэгэхээр энэ шинэ дэг хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой мөн хууль тогтоомжийн хуулийн хэрэгжилтийн дагуу яаралтай горимоор өргөн мэдүүлсэн хуулийг Улсын Их Хурлын гишүүдийн олонхын дэмжсэнээр яаралтайгаар хэлэлцэх эсэх асуудал шийдвэрлэгдэж явахаар болж байгаа. Сая бид бас Улсын Их Хурал дээр орж өчигдөр Ерөнхий сайдаас өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг бас Улсын Их Хурлын гишүүдийн олонхын саналаар шийдсэн байгаа. Тэгэхээр цаашдаа ийм байдлаар явна. Яг Ганбаатар гишүүний хэлж байгаа үнэн. Яаралтай нэрийн доор бас зарим бодлогын томоохон асуудлууд богино хугацаанд хөнгөн хуумгай гарах асуудлууд бас үүсэх талтай учраас Улсын Их Хурал энэ асуудалд хариуцлагатай хандаж ажиллана. Гишүүдийнхээ саналыг хүндэтгэж сонсож ажиллана аа гэдгийг бас хэлье.

2 дахь асуултад хариулъя. Улсын Их Хурлын даргын хувьд Ерөнхий нарийн бичгийн даргыг нэр дэвшүүлэх асуудлаар бас 2, 3 сонголттойгоор бас уулзалтууд хийсэн байгаа. Тэгээд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нь цэвэр төрийн албан хаагч байх хуулийн зохицуулалттай. Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллах хүн аль нэг улс

төрийн намын гишүүн байхгүй, энэ улс төрийн намаас бүрэн татгалзсан байх хуулийн заалттай учраас зарим нэр дэвшигч хүсэлт санал тавьсан нэр дэвшигчдийн зүгээс татгалзсан байгаа гэдгийг бас хэлье.

**Л.Энх-Амгалан:** Ганбаатар гишүүн тодруулъя.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Тэгээд 1 санал хэлье. Ер нь бол энэ аливаа хуулиудыг хэлэлцэхдээ өөрийнхөө тогооноос хальсан зүйлүүдийг Их Хурал бол хэлэлцмээргүй л байгаа юм шүү. Өөрсдөө ирээдүйд олох гэж байгаа зүйлийг энд ярьдаг, олох гэж байгаа зүйлдээ тааруулж хууль баталдаг тийм байж бол болохгүй шүү. Энэ бол үнэхээр том асуудал шүү. Олдсоныхоо дараа юм уу эдийн засгаа дээшлүүлснийхээ дараа тэр асуудлыг ярилцах хэрэгтэй. Тэгэхгүй бол бараг тийм мөнгө хэзээ ороод ирэх юм байна гээд түүнийхээ төлөө хууль яриад сууж байдаг ийм зүйл өнгөрсөн жилүүдэд байсан юм шүү. Үүнийг Баасандорж дарга аа, сайн анхаарна биз.

Тэр нөгөө Цэц рүү явчихдаг дарга чинь хэн билээ? Тэр дарга бол тэр асуудал дээр их тийм маш сайн анхааралтай ажилладаг байсан гэж би үзсэн. Тийм учраас ялангуяа эдийн засгийн асуудлуудыг ярихдаа тогооноосоо хэтэрсэн зүйлүүдийг Их Хурал руу оруулж ирэхгүй байхыг Тамгын газрын дарга их сайн анхаарах хэрэгтэй.

Тэгээд Байнгын хороод дээр ч гэсэн аливаа асуудлаас давсан янз янзын зүйлүүдийг бол ер нь санал хураалгахгүй л байх ёстой. Угаасаа тийм хуультай шүү дээ. Үүнийг би бас анхааруулж хэлье. Тэгээд Их Хурлын даргад хүсэхэд бол энэ удаагийн парламент бас эдийн засаг руугаа анхаарсан, хувийн хэвшил рүүгээ анхаарсан, тэр тал руугаа ер нь бол өмнөх 4 жилд бас нэг ийм эдийн засгийн асуудал ярихаар бараг боолчлогч, дарангуйлагч гэж цоллуулж их

хараалгадаг л даа. Энэ удаа бол их тийм олон энэ талыг дэмждэг бололтой хүмүүс их сонгогдсон юм шиг байна лээ. Тэгээд тэр хүмүүсийн үгийг бас сайн сонсоно биз дээ. Тэгж байж улс орон хөгжинө шүү дээ. Ер нь улс орны хөгжил гэдэг бол бизнес эрхлэгчдийн тэр эрсдэл үүрэх чадвар дээр л суурилдаг шүү дээ. Яаж эрсдэл үүрч улс орноо хөгжүүлэх вэ. Түүнээс биш тэгээд 1 улс төрчдийн худлаа үгэн дээр улс орон нь хөгжинө гэж бол байхгүй л дээ. Өнөө маргаашаа хараад л дуусах байх.

Тийм учраас ирээдүйгээ хараад тийм улс орны хөгжил рүүгээ чиглэсэн хуулийг баталдаг тийм парламент байна гэдэгт итгэж байгаа шүү. Үүний талд бол дэмжиж тууштай ажиллана гэдгийгээ бас илэрхийлье. Амжилт хүсье Баасандорж даргад. Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Тодруулгад хариулт өглөө. Сайнцог гишүүн.

**П.Сайнзориг:** Сайнзориг. Би бүх гишүүддээ бас өглөөний мэндийг хүргэе. Тэгээд Баасандорж даргыг бас нэр дэвшиж байгааг бол дэмжиж байна. Нэг 2 асуулт л байна.

1 дүгээрт, энэ аливаа энэ Ерөнхий нарийн бичгийн дарга бол дэгийн зөвлөх байж байгаа. Дэг гэдэг бол аливаа асуудлыг аль Байнгын хороогоор ямар горимоор яаж санал хураах вэ, ямар шийдвэр гаргах, хэдэн хувиар ч гэдэг юм уу шийдвэр гаргах вэ гэдэг асуудлыг хамгийн зөвлөгөө өгдөг том хүн байж байгаа.

Тэгэхээр энэ дээрээ бид хэд бас жоохон анхаарахгүй бол одоо жишээ нь газрын асуудлууд Эдийн засгийн байнгын хорооны асуудал өнгөрсөн хориод жил явж ирлээ. Явдаггүй ээ. Тэгээд газрын асуудал бол ерөөсөө төрийн байгууламж, хууль зүйн өмчлөх эрхийн асуудал байгаад байдаг. Уг асуудлыг нь ерөнхийдөө ийм орхигдуулж эдийн засгийн аспект талаас нь хараад

явчихаар ингээд Монголд бас энэ өмчийн болоод төрийн байгууламжийн асуудал энэ газраа дагаад бас нэлээн замбараагүй явж байна.

2 дугаарт, яг иргэний процесс гэдэг юм уу энэ бизнесийн эрх зүйг дэмжих зарим юмнууд Хууль зүйн байнгын хорооны асуудал жишээ нь Дампуурлын хууль Эдийн засгийн байнгын хороо дээр ингээд бас ерөөсөө л харьяалагддаг, хэлэлцэгддэггүй.

Дээрээс нь магадгүй бүр ярих юм бол төрийн өмчийн асуудал байгаа байхгүй юу. Бас л Хууль зүйн байнгын хорооны асуудал. Тэгэхээр би энэ Байнгын хороодын ажлын ачаалал, чиг үүргийн энэ балансыг бас цаашдаа зөв олох талаар Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий нарийн бичгийн даргаар дэвшиж байгаа хүн 2 ямар бодолтой байгаа вэ? Энэ дээрээ бас зөв тохируулга хийхгүй бол ядаж Газрын ерөнхий хуулийг энэ ХЗБХ юм уу, Төрийн байгуулалтаар хэлэлцдэг баймаар байна. Ингэж байж өөрөө эргээд энэ бас төрийн байгуулалтын хувьд сууриараа нэгдмэл байх, энэ өмчлөх эрхийн асуудал, иргэдийн өмчийн эрхийг бас хамгаалах асуудлыг бас анхаарахгүй бол энэ зүйлүүд ингээд орхигдоод байна. Эдийн засгийн байнгын хорооны нэг салбар юм шиг. Одоо энэ дарагдаж хоцорч байгаа ийм зүйл байна. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ.

2 дугаарт, би яах вэ зүгээр Улсын Их Хурлын Тамгын газарт бас ажиллаж байсан. Сүүлийн үед ингээд хууль аваад ороод ирэхээр яг тухайн асуудлаар мэргэшээгүй зөвлөхүүд ингээд томилогдож байгаа. Сүүлийн 2, 3 жил. Яах вэ зүгээр ажил, ачааллыг тэнцвэржүүлэхдээ зөвлөхүүдийн хувьд зөв байгаа боловч хуучин тэр мэргэшсэн, Байнгын хорооны яг мэргэшсэн зөвлөх, референтүүд ажилладаг энэ тогтолцоог ер нь 126-тай нэлээн реформын шинжтэй зүйлүүд хийнэ гэсэн ийм хүлээлттэй, зорилттой байгаа парламентын хувьд бас

юу гэж харж байгаа вэ? Яг эргээд л хуулиуд чинь ингээд тойрог байдлаараа зөвлөхүүд дээр явахаар яг тухайн асуудал дээр мэргэшээгүй хүмүүс дээр хүртэл хуваарилагдчихаад байгаа байхгүй юу. Тэгээд зөвлөхүүд яаж ажиллахаас бас Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны ажлын хэсэг, Байнгын хороо бас шийдвэрээ гаргахад бас чухал байгаа.

Тэгэхээр энэ дээр эргэж бодож байгаа зүйл бас нэр дэвшигчийн хувьд байгаа юу. Улсын Их Хурлын даргын хувьд бас ямар бодол байгаа юм бол оо гэдэг зүйл. Ийм 2 асуулт асууя.

**Л.Энх-Амгалан:** Одоо Амарбаясгалан дарга хариулъя.

Амарбаясгалан даргыг хариулахын өмнө би нэг хүлцэл өчөөд Энэ Ерөнхийлөгчийн юугаар Бутаны Хааныг тосох энэ арга хэмжээнд ордны гадаа оролцох юм байна. Тэгээд дэгийн тухай хуулиар хуралдаан даргалагч дараагийн хуралдаан даргалагчийг томилж орлуулна гэсэн ийм дэгтэй юм байна. Тэгээд энэ дээр Мөнхбаатар дарга. Сандаг-Очир. Сандаг-Очир гишүүн энэ хурлыг үргэлжлүүлээд удирдчих. Түр удирдаж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Би хариулт өгөх үү?

**Л.Энх-Амгалан:** Амарбаясгалан дарга.

**Д.Амарбаясгалан:** Түрүүн Ганбаатар гишүүний бас тодруулгад товчхон хариу өгье гэж бодож байна. Санал нэг байгаа зүйл юу вэ гэхээр энэ бизнесийн эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудал, эрх зүйн орчныг бүрэн баталгаатай болгох, ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой асуудлыг бүрэн зохицуулалт хийх чиглэл дээр энэ хуулиудыг багцаар нь авч, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайжруулах, засах энэ зүйл дээр бол манай Улсын Их Хурал бодлого гаргаж

ажиллая гэдгийг би бас чуулганы нээлт дээр хэлсэн. Өнөөдөр бас эдийн засгийн формын нээлттэй арга хэмжээ дээр хэлэхийг зорьж байгаа.

Тэгээд манай энэ санаачилга гаргаж байгаа гишүүд маань ажлын хэсгүүдийг байгуулаад, ахлаад яг энэ эрх зүйн орчныг бүрэн баталгаатай болгох, хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагаанд учирч байгаа төрийн дарамт, хүндрэл бэрхшээл юу байгааг бодитоор тодорхойлж засаж, залруулахад хамтарч ажиллая гэдгийг бас хэлье.

Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын Байнгын хороодын чиг үүргийн хувьд холилдсон, давхардсан зүйлүүд байгаа гэж бас зарим талаар харагдаж байгаа. Мөн мэргэжсэн мэргэжлийн зөвлөхүүдийг Байнгын хороодод ур чадвартай, мэдлэгтэй боловсон хүчнүүдийг ажиллуулахыг мэдээж бодлогоор дэмжиж ажиллана.

Тэгэхээр гишүүддээ би зориуд хандаж нэг зүйлийг хэлье гэж бодож байгаа юм. Байнгын хороо ч бай, Улсын Их Хурал ч бай чуулган дээр гишүүд маань бас энэ санаачилга гаргахтай холбоотой асуудал дээр 1 дүгээрт, саналаа хэлэхээс гадна өөрсдөө тодорхой төсөл боловсруулж, засаж залруулах тэр санаачилгыг хэрэгжүүлэхэд оролцож явмаар байгаа юм. Бүх асуудал зөвхөн Тамгын газар хариуцах ёстой, бүх газар, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцах ёстой, бүх асуудлыг хариуцсан Байнгын хорооны референт хариуцах ёстой гэж асуудалд аль болох хандахгүйгээр бүгдээрээ хамтраад, засаж залруулах, сайжруулах тэр бүх алхмыг хийж явъя гэдэг энэ зүйлийг нийт Улсын Их Хурлын гишүүддээ бас хэлэхийг хүсэж байгаа юм.

Өнөөдөр Монгол Улсад нэг 850 орчим хууль хэрэгжиж байна. 3000 гаран журам бас зохицуулалт хийж байна. Энэ бүгдийг илүү нарийвчлах, нийгмийнхээ хэрэгцээ шаардлагыг бүрэн хангадаг

болгохын төлөө Улсын Их Хурал бүрэн хүчин чадлаа дайчилж ажиллах учиртай. Тэгэхээр энд салбар бүрийн, мэргэжил бүрийн төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газар, Байнгын хороодын ажлын алба бүрэн хүчин чадлаа дайчилж ажиллана гэж ингэж бодож байгаа.

Тэгээд Их Хурлын даргын хувьд бас олзуурхаж байгаа нэг зүйл бол маш олон хуульчид энэ удаагийн Улсын Их Хуралд орж ирсэн. 27 хуульч гишүүн орж ирсэн байна лээ. Тэгэхээр энэ боломжийг бид бүрэн ашиглах ёстой. Ард түмний энэ сонголтыг бид үр дүнтэй 4 жил болгож өнгөрөөх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа шүү гэдгийг хэлье.

**Ц.Сандаг-Очир:** Нэр дэвшигчээс байгаа юм уу? Нэр дэвшигчээс асуусан асуултад 5 номерын микрофон Баасандорж хариулъя. 5 номерын микрофон.

**Б.Баасандорж:** Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан даргалагч болон Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Дэгийн зөвлөхтэй холбоотой асуулт асуусан. Улсын Их Хурлын тухай хууль дээр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурлын дэгийн зөвлөх байна гэж хуульчилж өгсөн байгаа. Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нь дэгийн тухай асуудлаар саналаа Ёс зүй, дэгийн байнгын хороонд хүргүүлнэ гэж зааж өгсөн байгаа.

Тэгэхээр миний хувьд бол хэрвээ та бүхэн итгэл үзүүлээд намайг томилох юм бол миний эхний ажил Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд холбогдох саналаа Ёс зүй, дэгийн

байнгын хороонд үргүүлнэ гэж бодож байгаа.

24 онд батлагдсан шинэ дэгийн хууль маань 16 бүлэг, 137 зүйл, 847 хэсэг, 1044 заалттай юм байна лээ. Би өмнөх хуулиудтай нийт 4 хуультай дүн шинжилгээ хийж үзсэн. Яг 20 оны хуультай харьцуулах юм бол нэг агуулгын 30 орчим хувьд нь өөрчлөлт орсон. Зарчмын нэг 10-15 хувьд нь өөрчлөлт орсон байна лээ. Тэгэхээр Ёс зүй, дэгийн байнгын хороондоо Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын хувиар бол саналаа бэлтгэнэ гэж төлөвлөж байгаа.

Сая Сайнзориг гишүүн нэг чухал асуулт асуулаа. Энэ газрын асуудал, төрийн өмчийн асуудал нь бол яалт ч үгүй Их Хурлын тухай хууль дээр жишээ нь газрын асуудал. Байгаль орчны байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо гэх мэт хэд хэдэн Байнгын хороо дээр хуваагдчихсан, салчихсан байгаа юм. Газрын асуудал өөрөө яг эрх зүйн асуудал байдаг. Яг Хууль зүйн байнгын хороогоор энэ газрын асуудал нь ордоггүй. Мөн төрийн өмчийн асуудлууд яг энэ Эдийн засгийн байнгын хороон дээрээ илүү төвлөрдөг. Бас яг эрх зүйн дүгнэлттэй холбоотой хууль зүйн чиглэлийн асуудлууд нь яг Хууль зүйн байнгын хороо дээрээ бас төдийлөн төвлөрдөггүй гэдэг асуудал дээр бол санал нэг байна гэдгийг бол хэлье.

Мэргэшсэн зөвлөхүүдийг бол энэ удаагийн парламентаар бүрдсэн түүний ажлын алба нь бол яг хэвээрээ, бүтэц зохион байгуулалтын хувьд хэвээрээ байгаа. Өөрөөр хэлбэл 76 гишүүний парламент 126 гишүүнтэй болсон. Тэгэхээр 126 гишүүний парламенттай хууль тогтоох байгууллагын ажлын алба нь өөрөө маш хурдтай, давсан гүйцэтгэлтэй, хандлагын өөрчлөлттэй, шинийг санаачилсан тийм хурдтай ажиллах ёстой гэж үзэж байгаа. Мэдээж хэрэг 126 парламентын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, стратегийн

хувьд маш оновчтой зохион байгуулалтаар өөрчлөгдөх нь бол гарцаагүй гэж үзэж байгаа.

**Ц.Сандаг-Очир:** Болсон уу? Сайнзориг гишүүн тодруулъя гэж байна.

**П.Сайнзориг:** Би бас Улсын Их Хурлын даргын хэлж байгаа зүйлийг бас талархаж хүлээж авч байна, бас залуу гишүүний хувьд байгаа. Тэгэхдээ энэ дээр идэвхтэй ажиллая. Өнөөдөр 1997 онд батлагдсан Дампуурлын хуулийг бид нар шинэчилж чадахгүй байгаа. 97 онд батлагдаад 98 онд энэ хуулийг засах ёстой юм байна. Монголд бизнесийн эрх зүйн орчин хөгжихөө больчихлоо. Бизнес рүү орж болж байна, гарч болохгүй байна, эсвэл энэ бизнесийн эрсдэлийг ерөөсөө шүүхийн оролцоотойгоо хуваарилж чадахгүй байна гэдэг асуудал ингээд 20 хэдэн жил яригдаж байна. Энэ асуудлыг ОУВС-аас тавьдаг. Холбогдох хуулийн төслийн Засгийн газраас өргөн бариад 4, 5 жил ингээд Эдийн засгийн байнгын хороо дээр гацдаг. Уг асуудлыг авч явъя гэхээр энэ цэвэр хууль зүйн асуудал байдаг байхгүй юу. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөөсөө үргэлжлэл.

Тэгэхээр энэ чиг үүргүүдийг зөв болгохгүй бол бас олон асуудлууд ингээд гацаастай байж байна. Газрын асуудал. Газрын ерөнхий хуулийг нь ядаж Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хороогоор хамтран хэлэлцэж байж энэ Үндсэн хууль болон иргэний хуультайгаа энэ өмчийн эрхийг зөв болгомоор байна. Энэ ТӨК-ийн болон энэ компанийн эрх зүйн асуудал бас Эдийн засгийн байнгын хороо дээр байгаад байгаа. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо гэхээсээ илүүтэй энэ ХЗБХ буюу тухайн тэр хуулийн этгээдийн засаглал, зохион байгуулалтын асуудал байхгүй юу.

Тэгэхээр энэ зүйлүүд ингээд бас бизнесийн эрх зүй дээр бас ингээд чөдөр тушаа болж байгаа энэ зүйлүүдийг бас гишүүд маань ч гэсэн анхаарч бас Эдийн

засгийн байнгын хорооны энэ хэт ачааллыг хуваалцах бусад Байнгын хороотойгоо. Энэ асуудлыг анхаараач ээ гэдэг зүйлийг би бас эцэст нь хэлье.

Тэгээд Баасандорж даргыг дэмжиж байна.

### **Ц.Сандаг-Очир:** Баярлалаа.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилж, чөлөөлөхтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Тэмүүжин гишүүн, Пүрэвдорж гишүүн, Батбаатар гишүүн.

Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Ерөнхий нарийн бичгийн даргатай холбогдуулаад гэхээсээ илүүтэй нөгөө парламент өөрөө эхний зохион байгуулалт, бүтцээ хийж байгаа учраас гэдэг агуулгаар нэг 3, 4 санаа хэлэхийг хүсэж байгаа юм.

1 дүгээрт, ер нь бол Засгийн газар нэлээн хүчирхэг болох шинжтэй байна. Одоо өргөн баригдаж байгаа энэ хуулийнх нь төсөл дээр байгааг нь харахаар эрхэлсэн сайд гэх мэтчилэн ингээд дараа нь 16 сайдыг нэмнэ гэх юм бол бараг энэ чинь 30, 40 сайдтай Засгийн газар болох гэж байгаа юм шиг байна. Ийм үед бол парламент өөрөө дахиад толгой дээрээ Засгийн газраа гүйцэтгэх эрх мэдлээ гаргаад тавьчхаад суух юм уу эс үгүй бол хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хуульд байж байгаа энэ төрийн эрх барих дээд байгууллага гэдэг энэ чиг үүргээ хэрэгжүүлэх хэмжээнд ирэх юм уу гэдэг дээр бас нэг жоохон анхаарч ажиллах шаардлага гарах байх.

Өмнөх, уул нь бол одоогоос 14 жилийн өмнө зөвлөмж байдлаар ирсэн байсан нэг зөвлөмжийг бид нар хэрэгжүүлж чадахгүй байгаа юм. Тэр нь

юу вэ гэхээр Улсын Их Хурлын дэргэд бид ажлаа хариуцан тайлагнадаг гэдэг нэр өгчхөөд байдаг нэг хэдэн байгууллага байдаг. Гэтэл тэр байгууллагуудынхаа бүгд биш гэхдээ нэг тодорхой хэсгийг нь парламентын хяналтыг бие даасан байдлаар хэрэгжүүлдэг. Бид одоо эженсиг гэдгээр нь хөгжүүлэх цаг болчихсон юм байна. Тухайлбал Аудит, ХЭҮК, ТАЗ гэдэг энэ 3 байгууллага. Энэ 3 байгууллага одоогоор бол яаж байна вэ гэхээр Үндсэн хуулийн эрх мэдэл хуваарилалтын хаана ч биш. Зүгээр Улсын Их Хурлын дэргэд ажлаа хариуцан тайлагнадаг гэж байгаа боловч мандатаа хаанаас авдаг юм, ямар зорилготой ажилладаг юм гэдэг нь тодорхойгүй байгаад байгаа юм.

Парламентын засаглал бүхий улс орнуудад яг энэ төрлийн 3 байгууллагыг чинь бол юу гэж хэлдэг вэ гэхээр парламентын хяналтыг бие даасан байдлаар хэрэгжүүлдэг байгууллага гэж хэлж байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд нь ажиллах гэхээр мэргэжлийн ур чадвар дутдаг, эс үгүй бол улс төржөөд байдаг учраас парламент мандат өгөөд яг энэ 3 институцээр дамжуулж, Засгийн газрыг бүрэн хянах гэж оролддог.

Тэгэхээр одоо бид яг энэ 3 байгууллагаа саяын агуулгаар нэг өөрчилж шинэчлэх цаг болсон байх.

2-т нь, дахиад би одоо өөрийнхөө 12 жилийн өмнө болсон нэг үйл явдлыг сануулж хэлэх гэж байгаа юм. Америкт очоод, би тэгэхэд Хүний эрхийн дэд хорооны дарга байсан юм. Америкт очоод Конгресс дээр Хүний эрхийн дэд хороотой нь уулзъя гэсэн чинь тэд нар над руу ингээд гайхаад байсан. Хууль зүйн байнгын хороонд чинь харьяалагддаг ийм байгууллага байна уу гэсэн чинь манай гадаад департамент буюу гадаад бодлого дээр ийм байгууллага байгаа. Яагаад гэвэл хүний эрх гэдэг энэ ойлголт чинь олон улсын хэл болохоос биш үндэсний дотоод хэл биш. Тэгэхээр нь би дахиад зөрүүлээд



иргэний үндсэн эрхийнхээ тэр хэсгийг хянадаг институт чинь парламент чинь хаана байна гэсэн чинь хэрвээ Хууль зүйн байнгын хороо дээр байгаа бол шууд цагдаа, тагнуул, АТГ ч гэдэг юм уу байгууллагаар нь нэрлээд хяналт тавьдаг бүтцүүд байдаг юм шүү. Ийм хүний эрх гэдэг ерөнхий гарчигтай ажилладаггүй институт байдаггүй юм гэж.

Киргиз манайхаас түрүүлээд хийчихсэн байсан. Хууль зүйн байнгын хороо дээрээ шууд Цагдаагийн хяналтын дэд хороо гээд. Одоо бид бол дахиад нэг хүний эрх гээд олон улсын стандарт яриад байдаг биш, ядаж Монгол Улсын Үндсэн хууль дээр байгаа иргэний үндсэн эрхээ бүрэн хянаж чадах хэмжээний парламентын хяналтын институт болох ёстой. Тэгэхийн тулд ХЗБХ дээр Хүний эрхийн дэд хороо гэхээс илүүтэйгээр одоо дотоод хэрэг, хууль зүй, одоо жастис гэдэг үгийг нь нэмж байх шиг байна. Яг энэ чиглэлийнхээ хяналтыг тавьж хийж чадах хэмжээний бүтцийг нь бий болгох ёстой байх.

Дахиад яг энэ дээр хяналтыг нь сайжруулахтай холбоотой энэ гадаад болон Аюулгүй байдлын байнгын хороо дээр байдаг Тусгай хяналтын дэд хороогоо салгах ёстой. Цэрэг, тагнуул 2 бол тусдаа байж болно. АТГ, цагдаа гэх мэтчилэн Монгол Улсын иргэн рүү халддаг, гэмт хэрэгтэй тэмцдэг энэ чиг үүргийн байгууллагуудыг гүйцэтгэх ажилтай холбоотой хяналтыг нь ХЗБХ буцааж татаж авах ёстой шүү. Энэ манай гадаад бодлогын асуудал ерөөсөө биш. Энэ өөрөө дотоод хэргийн асуудал байхгүй юу.

Тийм учраас Дотоод хэрэг Хууль зүйн яамыг хянаж байгаа Байнгын хороо нь байх ёстой. Тэгээд энэ чиг үүргүүдийг бас бид нар янзалж авах ёстой байх шүү. Дахиад яг энэ парламентыг сайжруулахтай холбоотой ер нь бол дэгийг хуулиар шийддэг тэр дундаа өмнөх парламент нь арынхаа парламенттай яаж ажиллахыг шийддэг

тогтолцоо бол байж огт болохгүй. Парламент болгон амьд, өөрөө өөрийгөө үүсгэн байгуулдаг зохион байгуулалт учраас парламент болгон өөрийнхөө дэгийг, өөрийнхөө зохион байгуулалтыг хийж байх ёстой, шинээр. Би энэ дээр нэг зүйл дээр гайхаад байгаа. Ёс зүй, дэгийн байнгын хороо гээд тусдаа нэг ийм Байнгын хороо байгуулчихсан. Дэгтэй холбоо асуудал тийшээ явчихсан. Энэ ер нь аль улсын туршлага юм бол? Бид нар нэг эргэж харах хэрэгтэй байх. Уул нь бол энэ дэг буюу төрийг өөрийг нь анх үүсгэж ингэж зохион байгуулалтыг нь хийж байгаа институт нь ТББХ энэ байхгүй юу. Энэ Байнгын хорооны хамгийн чухал өөрийгөө эмхэлдэг эрх мэдлийг нь яагаад тийшээ шилжүүлчихсэн юм бол? Би түүн дээр бас нэг гайхаад байгаа юм.

Тэгээд үүнийг бас нэг жоохон нөгөө туршлагыг нь хараад аль улсын туршлага юм, ямар улсад ийм туршлага байгаад энэ ингээд хийчихсэн юм. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хорооны хамгийн чухал өөрийгөө эмхэлж чаддаггүй ТББХ гадагшаа Монгол Улсын Засгийн газрыг болон бусад институцийг эмхэлнэ гэж байхгүй шүү дээ. Тэр эхний цэг өөрөө нэг буруу хатгагдсан байгааг бас нэг эргэж харах цаг болсон юм биш үү гэж бас бодоод байгаа юм.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа.  
Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Бүгдэд нь энэ өглөөний мэнд. Тэгэхээр Сайнзориг гишүүн бас Хууль зүйн яаманд ажиллаж байсан, дээрээс нь гүйцэтгэх буюу хотын салбарт ажиллаж байсан нэлээн олон хууль дээр нухаж ажилласан байх. Тийм учраас таны туршлага бол нэлээн сайн болсон байх. Гэхдээ манай энэ Улсын Их Хурлын энэ Байнгын хороод энэ Улсын Их Хурлын яг энэ референтүүд, ажилтнууд нар бол маш сайн хүмүүс байгаа. Ер нь бол яг энэ 2016 он эхэлж байхад нэлээн олон сайн ажилтнуудын маань цалин багатай учраас компаниуд,

дээрээс нь бусад цалин өндөртэй төрийн байгууллагууд авч яваад байсан учраас 2 ч удаа цалинг нь нэмсэн. Тэгээд үүний үндсэн дээр бас энэ хүмүүсийн нийгмийн асуудал нь гайгүй болж, эндээ үлдэх хандлага нь илүү болсон юм байгаа юм.

Тэгэхээр Баасандорж дарга, дээрээс нь Амарбаясгалан дарга нар бас нэг зүйл дээр анхаараач. Энэ дахиад л энэ салбар салбарын ажилтнуудын цалинг тус тусдаа хууль оруулж ирээд, дахиад нэмээд байгаа юм. Одоо хууль, хяналтын байгууллагууд, дээрээс нь хуулийн байгууллагууд бол маш их тийм хүмүүсийнхээ цалинг нэмсэн. Тийм учраас энд ажиллаж байгаа хүмүүс тийшээ явах хандлага бас байгаад байгаа юм. Дахиад л байгаа, бий болж байгаа. Өөрөөр хэлбэл тэр чинь аль илүү цалинтай газар луу л явна шүү дээ. Энэ хууль бичдэг, хууль боловсруулдаг энэ хүмүүс чинь чаддаг ажлаа л хийнэ, чаддаг ажлаа хийх дээр хаачихдаг вэ гэх дээр компаниуд руу зөвлөхөөр явдаг. Аль эсвэл төрийн байгууллага дээр өндөр цалинтай газар луу очдог л тэр цалингаа дагаад л амьдардаг ийм хүмүүс байхгүй юу даа.

Тийм учраас энэ хүмүүсийн цалин цавааг нэмэгдүүлэх тал дээр ирэх оны 1 сарын 1-нээс бас нэг жоохон анхаарч ажиллах юм бол бид нар илүү сайн хуулийн багтай, хууль сайн боловсорч гарч ирдэг ийм л байгууллага болж чадна л гэж би харж байгаа. Тийм учраас энэ тал дээр Баасандорж дарга илүү сайн анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Баярлалаа. Амжилт хүсье, сайн ажиллаарай. Сайн, муу ажиллахыг нь би хэлээд ч ялгаа ч үгүй л байх. Зүгээр туршлага юм уу, туулсан зам хүний барих байр сууринд асар их нөлөөтэй байдаг, миний бодлоор. Тэгэхээр нөгөө туулсан зам нь болохоор

төрийн алба, кабинетын зарчим, командын зарчим тэр замаар яваад ирчихсэн учраас нэг зүйл дээр жоохон түлхүү хандлага тал дээр анхаарахыг бодоорой гэж хүсмээр байна. Тэр нь юу вэ гэхээр парламент бол төлөөллийн байгууллага. 3 сая 500 мянган хүн нэг дор цуглаад хуралдаж чадахгүй учраас төлөөллийн байгууллага болгож, энд төлөөллүүд нь ирчихсэн байгаа. Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга тэр чиглэлээс нь анхаарч ажиллах нь хамгийн эхэнд тавигдах зарчмуудын нэг байх. Засгийн газар бол хамаагүй. Тэр чинь бол бодлого нь гараад, мөрийн хөтөлбөр нь гараад, шийдвэр нь гараад, кабинетын зарчмаар ингээд явчихдаг учраас.

Тэгэхээр Их Хурлын гишүүдийн оролцоог хангах, улс төрийн намуудын оролцоог хангах, цаашлаад тэд нараар дамжаад иргэд, сонгогчдын оролцоог хангах энэ чиглэл рүү илүү анхаарч ажиллахыг хичээгээрэй гэж хүсье. Өөр зүйл алга даа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Өглөөний мэнд хүргэе. Баасандорж даргыг бол дэмжиж байгаа. Яагаад вэ гэхээр хуульчийн хувьд бол их чадвартай юм билээ. Тэгээд бид нар бас Оюутолгойн хэлэлцээр эд нар гээд нэлээн олон ажлын хэсгүүд дээр бол цуг ажиллаж байсан. Тэгэхээр томилгоо бол нүдээ оносон байна.

Нэг маш товчхон зүйл хэлэхэд энэ анх анхааруулж хэлэх зүйл юу вэ гэхээр 126 гишүүнтэй анхны парламент байгаа. Тэгээд маш олон шинэ гишүүд ирсэн байна. Тэгээд өрөө, байрны асуудлаас авхуулаад энэ учраа олохгүй олон хүмүүс бол байна. Тэгээд түүнтэй холбоотойгоор энэ зохион байгуулалт руугаа яаралтай орж ажиллахыг бол хүсэж байна.

Тэгээд энэ хүмүүстээ нэг ориентэйшн өгдөг шүү дээ, шинэ

гишүүддээ, тийм. Тэгэхээр тэр ориентэйшнээ бас яаралтай өгөх хэрэгтэй юм байна даа гэдэг мэдрэмж төрөөд байна л даа.

Тэгээд нөгөө талдаа бас энэ маш олон ийм залуучууд бас ингээд орж ирж байгаа болохоор энэ нөгөө байшингийнхаа энэ зохион байгуулалт дээр бас жаахан анхаармаар юм шиг л санагдаад байна л даа. Дугуйтай ирж байгаа, машинтай ирж байгаа хүмүүсийнх нь боломжийг нь гаргаж өгөх, тэгээд энэ кофе шоп эд нарынхаа тэр боломжийг нь бас нээж өгөх чиглэлээр илүү бас нэг нээлттэй 126 парламент, тэгээд ЗГ энэ тэр гараад явчих юм бол илүү иргэддээ нээлттэй байдлаар ажиллах тэр арга хэмжээг нь бол Их Хурлын Тамгын газраас илүү анхаарах болов уу гэж бас бодоод байна л даа. Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд. Энэ чинь парламентын л байшин болно гэсэн үг шүү дээ, тийм биз. Цаашдаа бол. Засгийн газар бол гарна гэдгээ зарлачихсан шүү дээ. Тэгээд гарах юм байна аа гэж ойлгож байгаа. Тэр нь ч бол зөв.

Тэгэхээр энэ бол парламентын иргэдэд нээлттэй ил тод ийм юм байх юм байна. Тэгэхээр хурлын дэг гэхээсээ гадна бас энэ парламент нь өөрөө энгийн бөгөөд иргэдээ их сайхан нээлттэй хүлээж авдаг. Тэгээд парламентын гишүүд нь хүртэл нэг дарга гэсэн агуулгаар биш тийм ээ, иргэдийн төлөөлөл гэсэн агуулгаар анхнаасаа ингээд соёлыг нь суулгаад өгөх юм бол энэ их зөв жишиг болох болов уу гэж бодоод байгаа юм.

Анх би Улсын Их Хурлын гишүүн болж байхад нэг кеттэй орж ирж байсан. Одоо хүн болгон кет өмсдөг болчихсон. Тэгээд бодит байдал нь тэр. Тэр нь их зөв. Хүүхдүүд оруулдаггүй байсан, одоо хүүхдүүдээ оруулж байгаа нь бас сайн. Тэгээд анх нөгөө дугуйтай ирэхэд гадаа паркинг байдаг мөртөө заавал ингээд пиджактай ирэхийг шаардаад байдаг

байсан. Тэгвэл энд ингээд иймэрхүү зохицуулалтууд аль болох энгийн болоод яах юм бол жижигхэн зүйлээс чинь болоод энэ парламент чинь нээлттэй болж байгаа юм байна, өөр болж байгаа юм байна гэдэг чинь харагддаг юм.

Тэгэхээр тэр зохион байгуулалт дээр анхаарч ажиллаарай гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна. Санал хураалтыг гар өргөж, илээр явуулна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Дамдины Энхбатыг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

19 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2. Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

1 дэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

09.29 цаг

2 дахь хэлэлцэх асуудалдаа оръё.

**“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэллээ.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйл дээр.

Тогтоолын төслийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэн уншиж танилцуулах вэ? Тэмүүжин гишүүн уншиж танилцуулна.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө. 27.3-д Засгийн газрын гишүүн Улсын Их Хурал тангараг өргөх журмыг Улсын Их Хурал батална. 45.2-т энэ хуулийн 45.1-д зааснаас бусад асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид тухайлан заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн байна.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Тараасан уу? Энэ тараагаагүй юм байна. Тогтоолын төслийг танилцуулъя, уншаад.

Тогтоолын төсөл. Хавсралтад өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тогтоолын үндэслэх хэсгийн тус тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журам”-ын 1 дэх заалтын “31 дүгээр” гэснийг “27 дугаар гэж”, 10 дахь заалтын “Засгийн газрын гишүүн тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу тангаргийг ээлжээр уншина” гэснийг “Засгийн газрын гишүүн тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүд давтан хэлнэ. Засгийн газрын гишүүн нөхөн томилогдсон тохиолдолд тангаргийг ганцаар өргөж болно.” гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу?

Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Уг нь асууя гээд дарчихсан байсан, гэрлээр нь.

**Ц.Сандаг-Очир:** Асуулт.

**Б.Батбаатар:** Энэ нөгөө өмнөх журмыг нь мэдэхгүй юм. Тэр 20 онд

баталсан журам, одоо өөрчлөгдөж байгаа журам.

Тэгэхээр нөгөө өмнөх журмаа мэдэхгүйгээр энэ журамд орж байгаа өөрчлөлтийг яаж байна гэж ойлгож батлах вэ? Тэгэхээр нөгөө дахиад Их Хурлын даргад би нөгөө иймэрхүү хэлэлцэх асуудлуудаа өгөөд урьдчилаад өгчих өө, гишүүд чинь би ч гэсэн үүнийг бол мэдэхгүй. 20 онд Засгийн газрын гишүүд ямар журмаар, ямар тогтоолоор, яаж тангараг өргөж байсан бэ гэдгийг.

Тэгэхээр өмнөх нь байхгүйгээр өөрчлөлтийн дугаар өөрчилсөн юм ороод ирэхээр хариулж мэдэх юм, санал хэлж мэдэх юм байхгүй болчихоод байна. Үүнийг яах вэ?

**Ц.Сандаг-Очир:** Асуултад Амарбаясгалан дарга хариулъя.

**Д.Амарбаясгалан:** Тамгын газрын зүгээс, Байнгын хороодын зүгээс бас энэ гишүүдийг материалаар урьдчилж хангах дээр бас бид анхаарч ажиллая. Цаг үеийн шинжтэй бас шуурхай явж байгаа учраас зарим зүйлийг бас нөхөж өгч чадаагүй байх. Ер нь яах вэ, Улсын Их Хурлаас энэ сайд нарыг Ерөнхий сайдын танилцуулснаар тэгээд танилцуулгыг сонсоод, сонссонд тооцоод гаргадаг байгаа.

Тэгээд урьдын ёслолын журам бол сайд нэг бүрчлэн тангараг өргөдөг, ёслол үйлддэг, Улсын Их Хурлын гишүүн бай, гишүүн биш бай. Ингээд бас давхардах ийм үйл ажиллагаа процессууд ихээхэн хэмжээнд явагдаж байна.

Тэгэхээр нэгэнт Ерөнхий сайд Улсын Их Хурлаас томилогдсон, өөрөө кабинетаа бүрдүүлэх Үндсэн хуулийнхаа эрхийг хэрэгжүүлж байгаа тэр утгаараа Улсын Их Хурал кабинетын гишүүдийг сонсож байгаа. Ингээд сайд нарын тангараг өргөх процессыг бол илүү хялбаржуулах нь зөв юм байна. Нэгэнт Ерөнхий сайд Үндсэн хуулиа эрхээ

хэрэгжүүлж байгаа учраас Засгийн газар дээр энэ процесс нь илүү явагддаг байх нь зөв байх. Энэ тангараг өргөх процесс нэг бүрчлэн явагддаг байсныг нийтээр нэг удаа явагддаг болгох. Энэ нь цаг хугацааны хувьд хэмнэлттэй, дээрээс нь бас Засгийн газрын танхимаар ажиллах зарчмыг хангаж өгөхөд дэмтэй, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бас дөхөмтэй ийм зүйл юм гэдэг байдлаар энэ тангараг өргөх процессыг хялбаршуулж оруулж ирж байгаа юм. Сайд тус бүр өргөдөг байсныг нийтээрээ нэг өргөдөг болгож байгаа юм.

**Ц.Сандаг-Очир:** Тодруулах уу? Батбаатар гишүүн тодруулъя.

**Б.Батбаатар:** Яах вэ, миний хардаад байгаа юм нь нөгөө хэлэлцэх асуудлуудыг өнөөдөр л чуулган дээр 15 асуудал, 17 асуудал ч байна уу дуржигнуулаад уншаад өнгөрчихсөн, өгөөгүй. Урьдчилан хэн нэгэн, нэг бол надад өгөөгүй байвал уучлаарай. Тэгээд бусдад нь өгчихсөн байгаа үгүйг мэдэхгүй байна. Манай Иргэний зориг ногоон намын гишүүдэд л лав өгөөгүй байна лээ. Тэгэхээр бүх гишүүдэд өгөөгүй гэж ойлгоод байгаа юм. Би.

Дараагийн асуудал нь юу вэ гэхээр Их Хурлын тухай Үндсэн хууль гэдэг юм уу Их Хурлын тухай, Засгийн газрын тухай хуулиараа Ерөнхий сайд бол батлагдчихсан. Их Хурал бараг л 100%-ийн саналаар батлаад гаргачихсан. Одоо Ардын нам, АН, ХҮН нам ороод ирэхээр яах вэ, ХҮН нам ялгаа байхгүй бүлэггүй. АН-ын бүлэг татан буугдах чиглэл рүүгээ явах байх. Ардын намтай нийлж нэг бүлэг болох байх. Эвслийн Засгийн газар хууль дээрээ тиймэрхүү заалттай байна гэж харж байгаа.

Тэгэхээр яаралтай горим гэдгийг ойлгож байна. Нөгөө талдаа энэ яаралтай горим нь өөрөө тодорхой асуудлуудыг Үндсэн хуультай 0 Засгийн газрын тухай хуультай, Их Хурлын тухай хуультай холбоотой асуудлыг халхавчлах зүйл

болж болохгүй юм. Түрүүн Ганбаатар гишүүн бас яриад байх шиг байсан. Яаралтай горим нэрийн доор хуулиудынхаа тэр нөхцөл, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудыг ярихгүйгээр энэ яаралтай орж ирсэн юм. Та нар зүгээр гараа өргөөд өг өө гээд яваад байвал Их Хурал нөгөө Үндсэн хуулиар олгогдсон эрхээ ч эдлэхгүй байна. Бид иргэдээс өгсөн төлөөллийн эрхээ ч эдэлж чадахгүй байна. Парламент өөрөө ард түмний төлөөлөл гэж үндсэн мөн чанар анх үүссэн парламентынхаа шинж чанараа ч хадгалж чадахгүй болж байна.

**Ц.Сандаг-Очир:** Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос оруулж ирсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

19-өөс 17 дэмжигдлээ.

Энэ тогтоолын төсөл батлагдсантай холбогдуулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд тогтоолын төслийг, санал, дүгнэлтийг хэн уншиж танилцуулах вэ? Батбаатар гишүүн уншиж танилцуулах уу. Хэн уншиж танилцуулах вэ?

Номинчимэг гишүүн. Номинчимэг гишүүн уншиж танилцуулъя.

2 дахь асуудлыг хэлэлцэж дууслаа.

09.38 цаг

3 дахь асуудал. Тийм байна. 2 дахь асуудлаа хэлэлцэж дууссан.

3 дахь асуудал.

**Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлнэ.**

Ерөнхий сайдын хувьд өөрийн биеэр танилцуулах юм шиг байна. Арай орж ирээгүй байна. Энэ болтол хугацаанд Пүрэвдорж гишүүн асуулт асууя гэнэ.

**Б.Пүрэвдорж:** Би энэ Их Хурлын анхдугаар чуулганы асуудлаар би нэг Амарбаясгалан даргаас нэг юм асууя гэж бодоод байгаа юм л даа. Яагаад гэвэл бид нарын энэ 128-тай энэ Их Хурлын чуулганы дэгийг түрүүчийн парламентын 76-тай гишүүд баталсан.

Тийм учраас энэ 26 чинь бас шал ондоо нөхцөл байдал бий болно. Дээрээс нь яг энэ дээр нэг тийм анхдугаар чуулган болон энэ ээлжит чуулган, намрын ээлжит чуулган байна шүү дээ. Энэ 2 дээр бол нэг гайгүй дэгээр явах юм шиг байгаа юм. Тэгээд түүнээс цаашаа ер нь бол нэг тийм хязгаарлалтын орчинд нэлээн явах, өөрөөр хэлбэл тийм үг хэлэх тэр боломжууд нь нэлээн хаагдсан ийм нөхцөл байдал руу орох юм байна.

Тийм учраас энэ анхдугаар чуулганы хэлэлцэх асуудлын 16.3.10-д Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах ийм зайлшгүй шаардлага байгаа юм.

Тэгээд энэ дээр нөгөө 2 намын бүлгийн дарга нар хоорондоо ярилцаад намрын чуулганаар энэ дэгийн асуудлыг авах тийм нэг эрх ч юм уу, юу ч юм, тийм ийм нэг тогтоол ч юм уу, аль эсвэл горимын саналаар шийддэг юм уу. Тэгээд намрын чуулган руу яг энэ дэгийн асуудлаа бас 126-уулаа ярилцаад шийдэх энэ боломжийг энэ анхдугаар чуулганаар авах ёстой. Түүнийгээ та бүгдээрээ ярьсан л байгаа шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Тэгэхээр 126 гишүүнтэй шинэ парламент эхэлж байна. Хуучин 76 гишүүнтэй парламентаар энэ дэгийн төсөл боловсруулагдаж батлагдсан байгаа. Би тэгээд ажлын хэсэгт орсон хүмүүстэй уулзаж ойлголт мэдээлэл нэлээд өргөн авсан. Ер нь 126 гишүүнтэй парламентад тодорхой үг хэлэх, асуулт асуух хязгаарыг бий болгохгүйгээр бас парламентын хөгжлийг бодитой болгож чадахгүй гэдэг асуудал 1 дүгээрт, тодорхой байгаа.

2 дахь зүйл бол энэ 126-тай парламент нь өөрөө жишээлбэл Германы Бундестагийн загварыг бас илүү судалж байж хийгдсэн ийм загвар байгаад байгаа юм. Тэгэхээр тэр Бундестагийн дэгийг бас загвар болгож, суурь болгож ажлын хэсэг ажилласан байгаа юм. Тэгээд тухайн үед ажиллахдаа улс төрийн намуудын бүлэг, удирдлагуудын төлөөллийг ажлын хэсэгт оролцуулж, саналыг тодорхой тусгасан. Гишүүдийн үг хэлэх эрхийг хязгаарлая гэхээсээ илүүтэйгээр илүү эмх цэгцэд оруулах бодлогыг баримталсан байгаа.

Гишүүд нөгөө дэгтэйгээ танилцчихсан байгаа. Өнөөдөр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл Байнгын хороодын дарга нар сонгогдсоноор байгуулагдана. Зөвлөлөөс журам гарахаар болж байгаа юм. Энэ дэгийн дагуу. Уг журам ямар журам байх юм бэ гэхээр ямар төрлийн хууль тогтоомжийг Улсын Их Хурал дээр ямар хугацаанд хэлэлцэх вэ гэдгийг тогтоодог журмыг өнөөдөр батлахаар бид зорьж байна.

Бид Их Хурлын даргын хувьд даргын дэргэдэх зөвлөлд 7 интервалтайгаар журмыг оролцуулна гэж ингэж бодож байна. Энэ дэгээр зохицуулагдахгүй хэд хэдэн хууль байгаа шүү дээ. Жишээ нь Хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв, төсвийн гүйцэтгэл зэрэг энэ дэгээр зохицуулагдахгүй гишүүн болгон асуулт асууж, үг хэлэх эрхтэй байгаа. Тэгвэл энэ дэгээр зохицуулагдаж

байгаа хууль тогтоомжуудыг хэлэлцэхэд 240 минут хамгийн дээд тал нь үндсэндээ 4 цагийн хугацаанд нэг хуулийг хэлэлцэж болно гэсэн үг. 240 минут өнөөдөр Улсын Их Хуралд сонгогдсон байдлаар нь харьцуулан үзэх юм бол 120 минут нь Ардын намыг төлөөлсөн гишүүд үг хэлэх, 100 орчим минутад нь АН-ыг төлөөлсөн гишүүд үг хэлэх, 20 орчим минутад нь намын улс төрийн бусад Улсын Их Хуралд суудалтай нам, эвслүүд үг хэлэх гэсэн ийм хуваарилалтууд хийгдэж байгаа. Жишээ нь тогтоол хэлэлцэх тохиолдолд 30 минут хуваарилагдана, 15 минут нь Ардын намын төлөөлөл, 10 минут нь АН-ын төлөөлөл, 5 минутад бусад намын төлөөлөл хүсэлт ирүүлсэн дарааллаараа эрэмбэлэгдэж зарим тохиолдолд рэндом хэлбэрээр сонголт хийгддэг байдлаар үг хэлээд явна гэж байгаа юм.

Тэгэхээр энд улс төрийн намын бүлгийн гишүүн байх, бүлэггүй намыг төлөөлж сууж байгаа гишүүн зэрэг харилцан эрх тэгш байх нөхцөл боломжийг энд харгалзан үзнэ. Жишээ нь бүлгийн гишүүн гэхээр үг хэлэх эрхээр хязгаарлагдах нөхцөл илүү байгаад байгаа бол бүлэггүй гишүүн нь байнга үг хэлэх нөхцөлөөр хангагдчих вий гэсэн болгоомжлол хүртэл энд байгаа. Тэгэхээр энэ бүгдийг зохицуулах журмыг бол бид өнөөдөр батална.

Тэгээд миний санал бол өнөөдөр Ёс зүй, дэгийн байнгын хороо ямар ч байсан дэгт тусгайлан саналгүйгээр шийдвэрээ гаргах нь зөв байх. Энэ батлагдсан дэгийг бид ядах нь ээ намрын чуулганаар бүтэн нэг хэрэгжүүлж үзэх нь зүйтэй байх. Энэ явц дээр Улсын Их Хурлын бүлгүүд, Улсын Их Хурлын гишүүдээс дэгт оруулах өөрчлөлтийн санал байх юм бол ажлын хэсгийг байгуулаад, өөрчлөлтийг хийгээд явах бүрэн эрх боломж байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Шинээр эхэлж байгаа зүйлийг бид бас туршиж, бүрэн хангалттай үзээгүй

байж байж өөрчилье гэж ярих нь өрөөсгөл юм гэсэн ийм байр суурьтай байгаа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Байнгын хороо 3 асуудал хэлэлцэхээс 2 асуудлаа хэлэлцчихсэн.

Одоо Засгийн газрын бүтцийн асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд өөрийн биеэр оруулж ирж танилцуулах учраас түр хүлээж байгаарай, гишүүд.

**Х.Тэмүүлэн:** Ингэчихмээр санагдаад байгаа юм. Одоо Улсын Их хурал шинээр зохион байгуулалтад орж байгаа энэ 126 хүнтэй зохион байгуулалтынхаа хүрээнд ер нь энэ парламентыг энэ том бүрэлдэхүүнээр нь ажиллуулахын тулд ямархуу бүтэцтэй ...

**Ц.Сандаг-Очир:** Байнгын хорооны хуралдааныг түр 15 минут завсарлууллаа.

#### ЗАВСАРЛАГААНЫ ДАРААХ ХУРАЛДААН

Гишүүдээ дуудаарай. Завсарлагаа дууслаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд хуралдаанаа үргэлжлүүлье. Хуралдааны танхимд цуглаарай.

Байнгын хорооны хуралдаанаа эхэлье. Ажлын хэсгийнхнийгээ дуудаарай. Ажлын хэсгээ дуудаж байна уу. Дуудсан уу.

Ирц хүрч байгаа учраас хурлаа эхлээд явчихъя. Гялс дуудчих.

Ажлын хэсгийнхэн суугаарай.

Байнгын хорооны хуралдааны завсарлага дууслаа. 3 дахь асуудлаа хэлэлцье. 3 дахь асуудал.

**Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг явуулна.**

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Бямбажавын Ганбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Дагдандоржийн Амгаланбаатар Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Пүрэвийн Зохихсүрэн Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Очиржавын Дөлгөөнтуул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын референт.

Ингээд Байнгын хорооны хуралдаанд хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхий сайд танилцуулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Эрхэм Улсын Их Хурлын гишүүд та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хуулийн хүрээнд Ерөнхий сайд Засгийн газрын бүтцийг оруулж ирж батлуулах ийм журамтай. Өмнөх бүтцээс юугаараа ялгаатай вэ, цаашдаа юуг харж байгаа вэ гэдэг дээр л илүү тайлбар өгчих нь зөв байх. Яагаад гэхээр тараагдчихаж байгаа учраас. Цаг хэмнээд.

Бид, манай бүтэц ер нь бол 90-ээд оноос өмнөх ийм бүтэц дээрээ бүтэн шинэчлэл хийж чадаагүй. Ингээд нэг ийм хагас пост коммунист, хагас либераль маягийн ийм бүтэцтэй болчихсон ийм байгууллага. Үүн дээр бүтэн үнэлгээ хийгдсэн ийм 4 том шинжилгээний дүгнэлт бол байдаг. НҮБ-аас ч, АХБ-аас ч, холбогдох 2, 3 сангаас мөн сүүлд нь Сингапур улсын зарим зөвлөхүүд өгсөн



ийм үнэлгээ байдаг. Гэхдээ энэ үнэлгээнүүдийн бас аль аль дээр нь тулгуурлаж яг ийм бүтэн хэмжээний цогц реформ бол хийгдээгүй.

Тэгэхээр энэ бол Монгол Улсын хөрсөн дээр өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд явсан бүтэц дээр тулгуурлаад, гэхдээ ерөнхий чиг хандлагыг сонгодог буюу Англи, Герман, Сингапур зэрэг парламентын гишүүд нь манайхтай төстэй гэхдээ холимог тогтолцоотой ийм улс орнууд руу оруулах нь бол зүйтэй юм гэдэг ийм эхний алхмыг хийх нь зүйтэй гэж үзсэн. Ингээд төсвийн үед бас энэ хэлэлцүүлэг илүү үргэлжлээсэй гэдэг агуулгаар бас олон нийт ч гэсэн мэдээлэл авах нь бол зүйтэй юм гэдэг байдлаар боловсруулсан байгаа.

Яах вэ, та бүхэн ажиглаж байгаа бол Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамыг бол бид нар Гэр бүл, хүний хөгжил гэдэг яг энэ агуулга руу доодох бүтцүүд нь ч гэсэн илүү тийм гэр бүлийн агуулга руу шууд хариуцах ийм тогтолцоо байх нь бол зүйтэй юм гэж үзсэн. Тэгэхгүй бол одоо зөвхөн нийгмийн хамгаалал гэхээр философи нь яг нийгмийн хамгаалал чиглэлийнх нь болохоор илүү тийм халамж талын чиг үүргээ барих ёстой гэж ойлгоод, хөдөлмөр болохоор боловсролын тогтолцоотой төдийлөн уялдаж өгөхгүй ингээд яваад байдаг. Гэтэл хөдөлмөрийн харилцаа бол өөрөө илүү хувийн хэвшилтэйгээ тэр хуйвалдах ийм зайлшгүй шаардлагатай байдаг. Тэгэхээр үндсэн концепцыг хүний хөгжил гэдэг цогц ойлголт юм гэдэг рүү хандуулах нь хүний хөгжил бол өөрөө гэр бүлийн асуудал юм. Гэр бүл бол нийгмийн хөгжлийн хамгийн анхан шатын нэгж юм. Эндээс бүх хүмүүжил, сайн сайхан зүйл эхлэх гэдэг энэ зүйлийг бүтцэд оруулж өгөх нь бол чухал юм гэж үзсэн.

Хүүхэд, гэр бүл, залуучууд гэдэг ойлголт хамт байх ёстой гэдэг ийм философиор агентлаг байгуулаад ингээд яваад ирсэн. Гэтэл үнэндээ яг хүүхдийн

асуудал, залуучуудын асуудал гэдэг бол маш тусдаа асуудал байдаг. Залуучууд бол илүү ногоон байгууламж, мөн илүү яг дэлхийн түвшний үйлчилгээ Монгол Улсад байх, илүү өөрийгөө илэрхийлэх ийм оролцооны хэлбэр байх гэдэг энэ чиглэл рүү илүү их явдаг. Тэгэхээрээ залуучуудыг соёл, спорт, аялал жуулчлалтай хамтатгаж авч үзэх нь бол зүйтэй юм гэж үзсэн. Энэ бол бас олон улсын нийтлэг жишиг.

Нөгөө талаараа бид соёлыг бол зөвхөн ийм урлагийн байгууллага гэж хараад байдаг. Гэтэл соёл бол өөрөө экспорт гэж бид нар үзэх хэрэгтэй. Тэр агуулгаараа энэ бол эдийн засгийн бүтээлч үйлдвэрлэл гэж үзэх хэрэгтэй. Спорт ч мөн адил. Бид спортыг зөвхөн олимпын төрлийн спорт гэж ойлгоод байдаг. Энэ бол эрүүл мэндийн асуудал гэж бас бид нарын хувьд үзэх хэрэгтэй, цогц ойлголт.

Аялал жуулчлал ч гэсэн энэ бол дэлхийг Монголд сурталчлах брэнд бүтээгдэхүүн бөгөөд экспорт гэж үзэх ёстой. Энэ энтертайнмент болон бүтээлч үйлдвэрлэлийн салбартаа манай залуучууд ид идэвхтэй холбогдож байж илүү ирээдүйд итгэх итгэл, эх оронч үзэл зэрэг зүйлүүд хийгдэх нь бол чухал юм гэж үзэж энэ бүтцийн яамыг хийсэн. Бусад газрууд ч гэсэн та бүхэн ажиглавал энэ бүтцийн яам байдаг.

Уул уурхайн салбар гээд ингээд явахаар зөвхөн ухах салбар гэж ойлгоод байдаг. Одоо бол бид нар уул уурхайгаа ухна. Гэхдээ ногоон эрчим хүчинд бас юу ногоон байгууламжид ээлтэй байна, дэвшилтэт технологид тулгуурласан байна, аж үйлдвэржсэн байна, мөн уул уурхай бол өөрөө хүртээмжтэй байна гэдэг энэ философи руу явахгүй бол уул уурхай гэхээр энэ бол зөвхөн нэг тийм ухдаг салбар гээд үүнээсээ болоод хөрөнгө оруулалт болон орон нутаг ч гэсэн байгаль сүйтгэдэг гэдэг энэ агуулга руу ороод явчгаж байгаа.

Тийм учраас саяхан батлагдсан Баялгийн сангийн тухай хуулийн үзэл баримтлал бол уул уурхайн салбар буюу эрдэс баялгийн салбарыг дэмжиж байгаа орон нутаг бол түрүүлж хөгжинө. Энэ бол орон нутгийн хөгжлийн сан гэнэ. Ашигтай байгаад ноогдол ашиг хуваарилах нь бол хуримтлалын санд орно. Энэ бол иргэдийн сайн сайхан амьдралын төлөө зарцуулагдана.

АМНАТ бол ирээдүйд хадгалагдана. Гэхдээ валютын нөөцөөр байна. Энэ бол өөрөө ирээдүйд хадгалах мөн улсын валютын нөөцийг өсгөхөд бол чухал юм гэдэг энэ агуулга руу хууль хийгдсэн.

Тийм учраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн үзэл санааг бас амьдруулах гэдэг агуулгаараа мөн одоо боловсруулалтыг нэг шатаар ахиулах. Нэг үгээр хэлбэл хилээр шууд эрдэс баялгуудаа түүхийгээр нь экспортлоод байхаас илүүтэйгээр адаглаад жишээлбэл Оюутолгойн баяжмалыг салгаад аль нь яг зэсийн баяжмалын, аль нь алт юм бэ гэдгийг тэнд нь нэгтгэх. Ийм хагас боловсруулах үйлдвэрийн энэ чиглэл рүү орох нь зүйтэй.

Тийм учраас Аж үйлдвэрийн яам бол уул уурхайгаа салгаж огт болохгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр манай экспортод 93 хувь уур уурхай, түүний 50 хувь нь нүүрс, бусад үлдсэн хувь нь бол алт, зэс, төмрийн хүдэр гээд ийм юунууд байгаа. Тийм учраас аж үйлдвэр, эрдэс баялаг гэдэг ийм философи буюу ийм юу идеологийн дагуу энэ яам байх нь бол зүйтэй юм гэж үзсэн.

Эрчим хүчний яам хэвээрээ.

Зам, тээврийн яам хэвээрээ байх нь зүйтэй гэж үзсэн.

Дэд бүтцийн яам гээд эрчим хүч, зам тээврийг нэгтгэе гэж үзсэн. Гэхдээ яах вэ яг манайд яг одоохондоо энэ бол яг нөгөө хэтэрхий том том асуудлуудтай

учраас нэг хүн бүхэлд нь хариуцах бол арай энэ цаг үед болоогүй. Цаашдаа бол ер нь Дэд бүтцийн яам гээд дотроо 3 яамтай байх, тэр бүтэц нь бол зөв юм гэж үзсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яам гэж ер нь алсдаа бол салах ёстой. Гэхдээ энэ удаа бас яамдын тоог нэмэхгүй агуулгаараа гол нь жастис буюу яг шударга ёс гэдэг тэр агуулга руу нь оруулж ирсэн. Ер нь шүүх ч гэсэн шударга ёсны ордон гэж хийгддэг байгаасай. Энэ нь бол гол нь ажиллаж байгаа албан хаагчид зөвхөн бид нар хууль сахиулаад байх биш бид нар бол шударга ёсыг нийгэмд тогтоох гэж байгаа энэ дотроо хууль тэгш үйлчлэх, хүний эрхийн асуудлууд ч гэсэн бүгд хамтдаа байх ёстой юм гээд. Тэгээд шударга ёс гэдэг зүйлээс бас бид нар нэг ийм ярьж чадахгүй айдаг болчхоод байгаа юм. Эсвэл ингээд нэг ийм хийсвэр нэг ийм агуулга юм шиг тал талаас нь тайлбарлаад.

Тийм учраас Хууль зүйн сайд бол шударга ёсны л сайд. Тэгээд энэ агуулгаа илүү гаргаасай. Албан хаагчид бас яг үүнийг бодоосой гээд. Мөн чуулган дээрээс ч гэсэн гарсан санал. Тэгэхээр яах вэ, өнөөдөр энэ хэлэлцүүлгийн явцад би ингэж оруулж ирээд тэгээд мэдээж яаж өөрчлөх, найруулах эрх бол парламентад бас байгаа учраас энэ дээр бидний хувьд ярилцаад явах нь бол зүйтэй юм гэж үзсэн.

Эдийн засгийн хөгжлийн яам бол Бодлого, төлөвлөлтийн яам. Хуучнаар Улсын төлөвлөгөөний комисстой адилхан ийм бүтэц. Үндэсний хөгжлийн газар гэж ойлгож болно. Энэ агуулгаараа ШУА-ийг Эдийн засгийн хөгжлийн яам руу татсан. Тэгэхгүй бол боловсролын салбар дээр шинжлэх ухаан гээд байхаар нэг л ийм салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинжлэх ухаан байгаад байгаа юм шиг ингэж ойлгогдоод яваад байдаг. Тэгээд их, дээд сургуулиуд нь бас уялдаж өгдөггүй.

Тийм учраас шинжлэх ухаан бол бүх салбарын нэвтрэх үнэт зүйл буюу тийм ээ, салбар дамнасан ийм асуудал юм гэдэг агуулгаар Эдийн засгийн хөгжлийн яам руу татаж авсан. Оюуны өмчийг бас татаж авсан байгаа. Тэр нь оюуны өмчийн асуудал бол бас эдийн засгийн бүтээлч үйлдвэрлэлтэй холбоотой юм гэдэг энэ агуулга нь бол зүйтэй юм гэж үзсэн. Мэдээж хамтарч байгаа энэ агуулгаар хэд хэдэн эрхлэх асуудлыг бас бид нар ярилцсан. Тэр нь бол худалдан авалт болон монопол мөн хөрөнгө оруулалт буюу гадаад худалдааны фифта энэ бол илүү ХҮН нам дээр байх нь зүйтэй юм гэж үзсэн. Яагаад гэвэл хамтарч байгаа гэдэг агуулгаараа, яагаад гэхээр төрийн худалдан авалтын ажиллагаа бол их тийм их хэл ам дагуулдаг зүйл.

Тийм учраас энэ дээр тийм том хэмжээний хөндлөнгийн том өөрчлөлтийг бас харж байгаа. 3 дахь цонхоор бас хийх боломжийг нь олгоё гэж үзсэн.

Яг тендерийн хувьд бол бас манай парламентын гишүүд анх орж ирж байгаа учраас энэ бол манай хөгжлийн бодлогыг маш их аргамжиж байгаа зүйл бол Тендерийн хууль. Тендер ороод 3 шатын шүүхээр явж байтал бараг тэгээд л ер нь бүрэн эрх дуусна. 3 жил шүүх дээр очоод гацчихдаг.

Тийм учраас Тендерийн хуулийг бол илүү тийм чанар луу тулгуурласан нэг үгээр манайх бол хамгийн хямдаар хийлгэх гэдэг ийм агуулга. Нөгөө цүнх баригчдын компани энэ тэр гэдэг бол яг үнэндээ энэ Тендерийн хуулиас маш их юм болж байгаа.

Тийм учраас энэ дээр том хэмжээний зоригтой реформыг бас хийж чадах болов уу гэдэг агуулгаар бас шинэ урсгал энэ асуудлыг хийж чадах байх гэдэг агуулгаар хийсэн.

Шударга өрсөлдөөний газрыг Монополын эсрэг газар гэж нэрлэсэн. Тэгээд Шударга өрсөлдөөний газар бол харамсалтай нь нэг хэвлэлийн бага хурал хийх хэмжээнд л ажиллаж ирсэн л дээ. Өнгөрсөн хугацаанд. Монополтойгоо тэмцэж чаддаггүй, тэр компанийнхаа төлөөлөл, лоббиг автаж гарч чаддаггүй. Ингээд яваад байдаг нь нууц биш. Парламент дээр ч гэсэн энэ том компаниуд бол төлөөллөө оруулаад ирчихсэн байдаг. Тэгээд л яг ийм том том асуулга дээр бол тэгээд ус тосоороо ялгардаг юм даа, ер нь бол. Тэгэхээрээ зориуд үүнийг Монополын газар гэж нэрлэсэн.

Тэгээд Их Хурлын гишүүдийнхээ эрхэлж байгаа бизнесийнхээ лоббинд автахгүйгээр, үнэхээр энэ монополыг задлахгүй бол Энхтүвшин Ерөнхийлөгч ч орж ирсэн байна. Тэгэхгүй бол энэ хэдэн банк, хэдэн уул уурхайн компани нь бизнесийнхээ бүх орчныг идээд ер нь бол дуусаж байгаа. Тэгээд бараг төмпөн шанаганаас бусад бүх юмыг энэ том компаниуд нийлүүлдэг болсон.

Тэгэхээр энэ дээр ХҮН нам томоохон хэмжээний реформыг бас хийж чадах байх гэж итгэж Монополын эсрэг хэмээх энэ газар бол зүйтэй юм гэж үзсэн.

Хот байгуулалт. Барилга, хот байгуулалтын яамыг Барилгын яам гээд ингээд бид нар нэршээд ирчихсэн. Тэгэхээр Барилгын яам гэхээр зөвхөн барилга барих тухай яам гэж ойлгоод ингээд яваад байдаг. Гэтэл хот байгуулалт гэдэг зүйл дээр бид нар ер нь өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд бас алдаа гарсан.

Тийм учраас хот байгуулалт гэдэг агуулга бол урд талдаа байх ёстой. Энэ бол өөрөө манай бүсчилсэн хөгжилтэй холбоотой бас том асуудал болж хувирна. Ингээд хот байгуулалтыг амьд организм гэж бодож цогцоор хийх ёстой. Мэдээж барилгын стандартын асуудал байна.

Дээрээс нь орон сууцжуулалтын асуудлыг шууд яамны нэрд оруулж ирж орон сууцжуулах тал дээр нэлээн тийм том хэмжээний реформ хийх нь бол зүйтэй. Тэгэхгүй бол орон сууцыг зөвхөн хувийн хэвшлийнхэн хийнэ, эсвэл бид нар зүгээр бодлогын дэмжлэг үзүүлнэ гээд нэг ийм юм ярьж явсаар байгаад л ингээд л бас нэлээн удчихлаа.

Тэгэхээр гэр хорооллоо барилгажуулахаас авхуулаад энэ олон зүйл дээр яам өөрийн үндсэн чиг үүрэг бол орон сууцжуулалт байна гэдгээ бодож яваасай гэдэг агуулгаар энэ зүйлийг хийсэн.

Мэдээж бусад зүйлүүд бол байгаа. Юуны эрхлэх асуудлын хүрээнд яах вэ, энэ юу байгаа. Яамгүй сайд нар байгаа. Ер нь нөгөө Үндэсний хорооны ахлагч нар гээд. Энэ бол бас ингээд их үр дүнтэй юм байна лээ. Ер нь бол бид нар төрийн албаны данхгар бүтэц гэдэг бол анхан, дунд шатанд байгаа тэр 200 орчим мянган давхацсан орон тоог л хэлэх ёстой. Үүнийг анхнаасаа бид нар бас зөв ойлгуулах хэрэгтэй. Түүнээс яг Төрийн ордонд ажиллаж байгаа нэг хүнийг хэмнэснээр ч юм уу энэ бас нэг их айхтар шууд тэгээд хэмнэгдчихгүй. Гол нь парламент өөрөө хүчтэй байж, ард түмнээс авсан мандатынхаа дагуу бүрэн эрх бол хэрэгжүүлэх ёстой байдаг.

Тэгээд яах вэ, мэдээж энэ удаа парламент шинэ тутам, парламентын гишүүдийн бас тоо нэмэгдчихсэн учраас үүнийг оруулж ирэх цаг нь биш гэж үзсэн. Гэхдээ цаашдаа бол яг сонгодог парламент хөгжсөн бүх улс орнууд бол эрхэлсэн сайд буюу манайхаар бол энэ яг дэд сайдын түвшинд байгаа хүмүүс ихэнх нь дандаа парламент дотроосоо байгаа. Тэр ч бүү хэл Төрийн нарийн бичгийн дарга хүртэл парламент дотроос томилогдож байгаа. Тэгэхээр яах вэ, мэдээж манайд бол одоохондоо энэ яригдах асуудал. Гэхдээ парламентын хэлэлцүүлгийн явцад та бүхэн цаашдаа энэ асуудлуудыг ер нь судалж үзэх нь бол

зүйтэй. Ингэж байж парламентын энэ олон мэргэжлийн ялгаатай байдлыг гүйцэтгэх засаглал, парламент дунд холбох гүүр болгож ашигласнаар боловсон хүчнийг шат дараатай бэлтгэх ийм боломж бас хангагддаг.

Нөгөө талаараа албан тушаал бүхэн өөрийн эрхлэх асуудалтай давхцахгүй хариуцлага хүлээх чадвартай байж байж л энэ өөрөө асуудлаа шийднэ. Тэгэхгүй бол асуудлаа шийдэж чадахгүй бас ийм албан тушаалууд байгаа юм. Жишээлбэл дэд сайд. Яах вэ, уучлаарай энд дэд сайд бас олон хүмүүс байна. Гэхдээ сайд нь харамсалтай нь эрх мэдлээ өгдөггүй. Төрийн нарийн бичгийн дарга нь эрх мэдлээ өгдөггүй. Ингээд дунд нь зөвхөн ажлын хэсгийн ахлагч болж хувирдаг. Гэтэл бусад улсад бол яах вэ гэхээр жишээлбэл, Дэд бүтцийн сайд, тэр нь Үндсэн сайд, зам тээвэр нь болохоор дэд сайд, гэхдээ шууд гарын үсгийн эрх мэдэлтэйгээр зөвхөн тэр асуудлаа л хариуцдаг.

Олимп болно. Олимпын бэлтгэлийн эрхлэх асуудлын сайд, тэр нь тухайн цагтаа хийгээд тэгээд аудитаар ороод ингээд тайлагнадаг ийм асуудал руу байдаг. Үүнийг олон улсын хэллэгээр бол Португалийн Министр нэгийг нь болохоор Стэйт Министр буюу үндсэн чиг үүргийн төрийн сайд. Нөгөөдөх нь бол эрхлэх асуудлын сайд гэж ангилдаг. Ийм 2 статус бол байдаг. Үүнийг бол цаашдаа бас бид нар ярилцах ёстой зүйл юм. Өнөөдрийн хувьд бол бэлэн биш юм аа гэж үзсэн. Гэхдээ тэр агуулга руу явж байгаа гэдэг агуулгаар энэ ерөнхий малгайг бол энэ концепц руу оруулж ирсэн гэдгийг та бүхэндээ бас хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Ингээд би танилцуулгаа товчилъё. Асуулт байвал хариулаад явъя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэлээ танилцуулсан Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ танд баярлалаа.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримттай холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя.

Тэмүүжин гишүүн, Батбаатар гишүүн, Зулхар гишүүн, Цогтгэрэл. Асуулт. Дараа нь санал үг авна. Цогтгэрэл гишүүнээр, 4 гишүүн тасаллаа.

Болороо асуух юм уу? Болормаа гишүүнийг нэмье. Ариунзаяа уучлаарай.

Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Асуулт. Засгийн газрын бүтэцтэй холбоотой нэг 4 асуулт байна.

1 дүгээрт нь, болохоор ХЗДХЯ-ны урд Шударга ёсны гэдэг үг ойлголт бичсэн байна. Хууль зүйн яамны ХЗДХЯ-ны өмнө Шударга ёсны гэдэг minister of justice гэдэг юм бичих гэж байгаа бололтой. Зүгээр концепцын хувьд Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор 2 нэг байгаа улс орнуудад хэрэглэдэг нэг нэр томъёо, энэ өөрөө. minister of justice гэдэг нь.

Тэгээд энэ Засгийн газрын бодлого дотор Үндсэн хуульд ямар нэгэн байдлаар өөрчлөлт оруулах замаар Ерөнхий прокурор гэдэг статусыг гүйцэтгэх эрх мэдлийн дотор авчрах гэж байгаа концепц яах юм уу гэж асууж байна. Энэ нэр томъёог ашиглаж байгаа учраас.

2-т нь, minister of justice гэж нэрлэж байгаа бол энэ чиг үүрэг доторх хамгийн чухал нэг зүйл нь юу вэ гэхээр Засгийн газрын дотоод дахь хүний эрхийн аудит хийдэг систем энд үүснэ гэсэн үг. Хууль зүйн яам дээр. Чиг үүргийнхээ хувьд. Тэгэхээр minister of justice гэдгийн чинь бас хамгийн чухал нэг чиг үүрэг хэрэглэгчийн эрх байхгүй юу. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байдлаар Хууль зүйн яамны чиг үүрэг өргөжих ёстой. Энэ нэр томъёог ашиглаж

байгаа бол. Гэтэл хэрэглэгчийн эрх чинь Шадар сайд дээр явж байна. Өмнөх олон жилүүд дээр угаасаа Хууль зүйн яамнаас гадуур явсан, энэ статус. Үүнийгээ шилжүүлэхгүй юм уу? Нэгэнт нэрийг нь ашиглаж байгаа учраас өөрт нь байх ёстой чиг үүргийг хэрэглэгчийн эрхийг хамгаалах, одоо та хэд бүгдээрээ Германаас жишээ авч байна. Германы чинь Хууль зүйн яамны хамгийн том чиг үүргийнх нь нэг нь энэ хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудал байдаг. Энэ өөрөө цэвэр хүний эрхийн асуудал. Манайх л нөгөө шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрх гэж холион бантан болгоод, аль аль нь юу болоод байгаа нь мэдэгдэхгүй ингээд завсардуулж орхисон байдаг.

Дахиад стандартчилал хэмжил зүйн асуудал Шадар сайд дээр байна. Энэ дээр концепцын өөрчлөлт гарах уу үгүй юу. Нэг зарчим байгаа шүү дээ. Төр бол хамгийн минимум стандартыг л тогтоож байгаа юм. Дээшээ байхгүй, дээшээ бол зах зээл, мэргэжлийн холбоод, өөр байгууллагуудад тогтоох ёстой. Түүнийг нь хангуулах гэж төр ажиллаж ерөөсөө болохгүй. Түүнийг нь мэргэжлийн холбоод нь юм уу эс үгүй бол зах зээл нь өөрөө хангуулах ажлаа хийх ёстой. Манайд юу явсан бэ гэхээр Стандартчилал хэмжил зүйн газар гээд хувийн хэвшил янз бүрийн байгууллагуудаас стандарт аваад ... /минут дуусав/

**Ц.Сандаг-Очир:** Тодруулж болно. Тийм. Асуултад Ерөнхий сайд хариулъя.

**Х.Тэмүүжин:** Түрүүний хүлээсэн хугацаагаа нөхөөд л авчихъя. Би нэг хэсэг хугацаа хүлээсэн шүү дээ.

**Ц.Сандаг-Очир:** Тэгээд та тодруулаад асуучих тэгэх үү? Нэмж ахиад нэг минут байгаад байна. Тэгээд та нэмээд асуух тодруулах чинь эрх чинь байгаа хугацаа чинь сая дуусчихлаа. Танд асуух микрофоныг чинь өгсөн шүү дээ. асуултад хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Энэ хуулийн байгууллагын будилааныг засах, зөв ойлголтыг бас нийгэм мэдэх гэдэг агуулгаар л энэ нэршлийг оруулж ирж, мөн хяналт тэнцлийн хүрээнд ч гэсэн бас энэ прокурор, мөрдөх байгууллага, шүүхийн байгууллагын дунд байгаа энэ бараг ингээд найз нөхөд байдаг юм даа. Яг үнэндээ хууль хяналтын байгууллага дээр хяналт тэнцэл гэдэг зүйл бас байхгүй болоод их удсан шүү, тийм ээ. Та үүнийг маш сайн мэдэх хүн нь.

Тийм учраас тэр агуулга руу нь л явуулах гэдэг агуулгаараа энэ нэршлийг олон улсын нийтлэг жишгийн дагуу оруулж ирж байгаа нь бол бодитой. Мэдээж Үндсэн хуультай холбоотой асуудал бол энэ бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал.

Тийм учраас энэ бол Их Хурал дээр илүү энэ үзэл санаа яригдах байх. Гэхдээ сонгодог агуулга руугаа л манайх алхам алхмаар ингээд явах л хэрэгтэй. Бид сая 126 болгодог бол энэ миний мэдэхээр 5 парламент дамжиж ярьсны эцэст хийгдсэн зүйл. Энэ хувь тэнцүүлэх тогтолцоо. Тэгэхээр бид нар өнөөдөр яригдаж байна аа гэдэг магадгүй, энэ удаагийн бүрэн эрхийн хүрээнд биш юм аа гэхэд нэг өдөр хийгдэхэд судлагдахуун болж бидний үг үлдэх нь л өөрөө их тийм зөв жишээ болов уу гэж бодож байгаа.

Ер нь бол мөрдөх байгууллагууд Засгийн газрын харьяанд байдаг. Прокурорын байгууллага УИХ, ингээд шүүх тусдаа байдаг гэдэг ийм ойлголттой. Гэхдээ яг бодитой байдал дээр яг энэ шударга ёсны гэдэг юм уу энэ асуудал дээр бол үнэхээр яг томилсон, томилсон хүндээ үйлчилдэг ийм бүтэц байдаг. Заримыг нь мэдэхгүй гаргаад явуулчихна, зарим дээр нь учиргүй хурдтай ажиллана. Ил тод биш. Зарим шүүх байгууллагын хурлууд тэр зөвлөлдөх тасалгаандаа ч хуралдаагүй гэж дуулддаг. Ийм асуудлууд бол байгаа.

Тэгээд гүйцэтгэх засаглал шүүх засаглалтай холбоотой ийм асуудал байна аа гэхээр шүүгч нарт долигонодог улс төрчдөд нь учиргүй их шүүмжилнэ. Нөгөө ард нь мөнгөтэй хүмүүс нь байдаг. Нэр усаараа холбоотой ийм зүйл зөндөө байдаг. Гэхдээ өдрөөс өдөрт хүмүүс үүнийг ялгаж хардаг болж байгаа. Хууль зүйн сайдыг хүн барьж хорьдог хүн гэж бодоод байдаг. Үгүй, тийм ямар ч эрх мэдэл байдаггүй.

Тийм ч учраас би үүнийг илүү бас ойлгоосой гэж бодож энэ удаа ч гэсэн хамтрахад сөрөг хүчин тийм ээ, АН ХЗДХЯ-ыг аваасай гэж би бас бодож байгаа юм. Энэ олон хүний эрхийн шүүмжлээд байгаа зөрчлүүд яг юу байв гэдгийг тухайн үед очсон хүн нь олж хараад, бодитой хүнээ хэлээсэй гэж. Тэр агуулгаараа энэ яах вэ, ер нь бас ОУБ-ын хяналт тэмцэл, тэгээд тэр агуулгаараа, тэгээд л Тэмүүжин сайд та нар нам дээрээ яриад л наад асуудлуудаа хийгээд л явж болно. Хүсэлт тавьсан. Энэ дээр би бол санал нэг байж болно гэдгээ бол илэрхийлж байгаа шүү дээ.

Тэгээд ингэх ёстой гээд яриад байх биш. Үгүй ээ, тэгээд л хийх л цаг юм биш үү дээ. Миний үлдсэн хугацаагаа ав ав. Тэмүүжин гишүүн, тийм дэг байдаг бол.

**Ц.Сандаг-Очир:** Тэмүүжин гишүүн тодруулъя.

**Х.Тэмүүжин:** Зүгээр, үнэхээр зоригтой шийдэл хийе гэвэл нэг 2 юм шийдмээр санагдаад байгаа юм. Нөгөө улс орнуудад чинь хууль тогтоох эрх мэдлийг буюу хэм хэмжээ тогтоох эрх мэдлийг зөвхөн Хууль зүйн сайдад шилжүүлж өгч байгаа юм. Зөвхөн Хууль зүйн сайдад. Дотоод хэргийн сайдад нэг ч хэм хэмжээ тогтоох буюу гадагшаа чиглэсэн хэмжээ тогтоох эрхийг өгөхгүй гэдэг зарчим ажиллаж байгаа. Дотоод хэргийн сайд бол зөвхөн процессинг хийх ёстой, гүйцэтгэл хийх ёстой. Хууль зүйн сайд нөгөө хүний эрх ерөнхий

прокурорын чиг үүрэг хэрэгжүүлдэг учраас легисрейшн буюу улсын парламентаас хэмжээ тогтоох эрхийг авна гэж байгаа юм. Манайд одоо бол энэ 2 албыг нэг хүн хийж байгаа учраас бүхэлдээ нөгөө процессинг хийх ёстой хүн чинь өөрөө хэмжээ тогтоогоод эхэлчхэж байгаа юм.

Тийм учраас ШШГБ, цагдаагийн байгууллага гэх мэтчилэн тэр байгууллагууд дотор дандаа иргэний эрхийг хязгаарласан заалтуудыг байгууллагын амбицаар бичээд эхэлчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр үүний сонирхлын зөрчлийг салгах юм ... /минут дуусав/

**Ц.Сандаг-Очир:** Хариулт.

**Л.Оюун-Эрдэнэ:** Тийм, өмнө нь санал солилцож байсан миний хувьд санал нэг байгаа. Тэгээд л та хууль тогтоогч. Энэ бүх асуудлыг яг зөв зүйл рүү нь чиглүүлээд ингээд явахад бол миний хувьд бэлэн байна.

Зүгээр, ганцхан зүйл дээр хүнд тохируулж хараад эхэлбэл бид нар тэгээд л алдаж эхэлдэг юм байна лээ. Хүнд тохируулж харж эхэлбэл тэгээд л алдана. Би энэ дээр мөнхийн юм шиг байна гэж бодвол алдана, эсвэл энэ аль нэг намд гарчихлаа гэж харвал алдана. Тэгэхгүй л харж чадвал энэ урт хугацаандаа зөв болно. Тэгэхээр тэр зарчмаа л бид нар харж чадвал тогтолцоогоо зөв болгоно. Хүндээ тохируулж хараад байвал алсдаа буруу болдог юм байна лээ.

Тэгэхээр тэр агуулга дээр миний хувьд дэмжээд, улсад хэрэгтэй гэдэг яг урт хугацааны агуулга дээр нь зөв байхын төлөө зогсож байгаа нь бол чухал. Энэ агуулга байж болох болов уу. Хүмүүс ч гэсэн яах вэ, гайхаж л байгаа байх. Яагаад Хууль зүйн яам гэж. Яагаад гэвэл энэ олон улсын нийтлэг жишиг нь л ийм юм билээ. Тэгж байж нөгөө хяналт тэнцэл бүрддэг. Тэр агуулгаараа энэ асуудлыг шийддэг. Тэгээд яах вэ, яваад

үзэх нь зөв байх аа л гэж би бодож байгаа юм. Тэгэхээр та бүхэнд онцгой бүрэн эрх шилжиж байна гэж ойлгож болно.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Батын Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Баярлалаа. Энэ шууд л асууя даа. Дараа нь ажлынхаа. Ногоон хөгжлийн, ногоон соёл иргэншил, ногоон амьдрал гэдэг талаар энэ уналттай яваад л байгаа. Хуучин Иргэний зориг ногоон нам Засгийн газарт 10 гаран жилийн өмнө орохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. Тэгээд үндсэн чиглэлийн яам болж байсан.

Тэгэхээр энэ дээр уг нь дэлхийн ногоон үзэл бол зүүн талын үзэл ч юм уу тийм юм байхаа больж байна шүү дээ. Баруун, зүүн аль нэг ийзн, ийзнд харьяалагдахгүй дэлхийн төв үзэл болчихлоо. Монгол гадагшаа хандах, гаднаас Монгол руу хандах маш том гарц гүүр бол энэ ногоон хөгжил. Ногоон соёл иргэншил. Ногоон соёл иргэншилтэй ийм ард түмэн бол их цөөхөн. Монголчуудын 4 улирал нүүдлийн соёл, иргэншил, өнөөдөр байгаа газар нутаг, цөлжилт, Ерөнхийлөгчийнх нь олон улсын өмнө дэлхийн индэр дээр амлачихсан амлалт, тэгээд улс төрийн намууд бол энэ чиглэлээр манай намын хаана нь ч хүрэхгүй л дээ. Яг үнэндээ бол. Бодол нь өөр байдаг юм байна лээ. Агуулга тэр харж байгаа өнцөг хандлага нь.

Тэгэхээр энэ дээрээ нэг жоохон анхаарч, анхаарах боломж байгаа юу гэдэг нэг асуудал байна.

Дараагийн асуудал нь юу гэхээр сөрөг хүчин Хууль зүйн яамыг аваад ажиллаач ээ гэдэг зүйл бас Засгийн газрын тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Үндсэн хуульд Засгийн газрыг олонх л бүрдүүлж байгаа. Сонгуулийн үр дүнгийн дараа олонхыг бүрдүүлж, нөгөө том ажлаа бодоод гээд ярьж байгаа олонхыг бүрдүүлж, 118

гишүүн Их Хурлыг бүрдүүлж ажиллах гэж байна. Олонхын бүлгийг. Тэгэхээр яах вэ, ХҮН нам ч яах вэ, бүлэггүй учраас хэлэх юм алга. АН-ын бүлэг татан буугдах байх. Миний ойлгож байгаагаар. Засгийн газрын кабинетын зарчим руугаа ороод.

Тэгээд Их Хурал дээр цааш цаашдаа олонх, цөөнх гэдэг зүйлээ АН засагт орсон улс төрийн хүчин цөөнх гэж яриад хэрэггүй шүү дээ. Энэ бол улс төр нь ч, хууль нь ч, ёс зүй байдгийн хувьд ч гэсэн сөрөг хүчин гэж яриад ч хэрэггүй. Засгийн газрын гишүүн байж Ерөнхий сайдынхаа сөрөг хүчин байна гэдэг ийм тоглоом ер нь хаана явдаг юм.

Тийм болохоор одоохондоо нөгөө сайд нар нь батлагдаагүй учраас дараа хэлнэ үү гэхээс одоо хэлээд байх нэг их тийм борооны өөдөөс шороо гэдэг шиг юм болох гээд байна. Энэ асуудлаа яаж харж байгаа юм бэ? Тэр хуулийн зөрчлөө ... /минут дуусав/

**Ц.Сандаг-Очир:** Асуултад хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Батбаатар гишүүн чухал асуудлыг хөндлөө. Ногоон хөгжилтэй холбоотой асуудал Байгаль орчны яам дээр ногоон хөгжил гээд тавьчихаар энэ зөвхөн нэг салбарын асуудал юм шиг бас болчихоод байгаа юм. Тэгэхээр ногоон хөгжлийг бид нар шинжлэх ухаан 2-ыг нөгөө нэвчих үнэт зүйл буюу салбар дамнасан асуудал гэж үзэж байгаа. Ийм 2 асуудал нь нэг нь шинжлэх ухаан, нэг нь ногоон хөгжил гэдэг энэ 2 асуудал байгаа.

Тэгэхээр ногоон хөгжил эрчим хүчин дээр яаж шилжилтээ хийх вэ. Ногоон хөгжлийг бид нар уул уурхай дээр яаж шилжилтийг нь хийлгэх вэ. Ногоон хөгжлийг бид нар хотын стандарт дээр яаж шилжилтийг нь хийлгэх юм. Ногоон хөгжлийг бид нар боловсролын салбарын бодлого дунд яаж оруулах юм. Ногоон хөгжлийг бид нар соёл дээр яаж

авчрах юм. Ногоон хөгжлийг яаж бид нар нүүдлийн соёл иргэншлээ хамгаалах дээр авчрах юм гээд энэ маань өөрөө ийм салбар дамнасан асуудал болж байгаа учраас Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн үндсэн малгайд бүх зүйл шинжлэх ухаан технологид тулгуурлана, бүх зүйл ногоон хөгжилд тулгуурлана гэж орсон байгаа.

Тэгэхээр ногоон хөгжлийн хувьд бол нэлээн тийм том үсрэлттэй.

Байгаль орчны яам дээр бол манайд тулгамдаж байгаа асуудлыг нь шууд тавих нь зүйтэй гэж үзсэн. Энэ бол цөлжилт. Энэ бол бэлчээрийн даац хэтэрсэн. Нэг үгээр хэлбэл манайд цаг уурын өөрчлөлт бодитой ирчхээд байна л даа. Жишээлбэл түрүү жил гэхэд бидний нөгөө мэддэгээр гурван 9, дөрвөн 9-д маш дулаахан байж таарсан. Нэг 9 нь маш хүйтэн байж таарсан. Цас маш эрт унасан. Сая ч гэсэн зун цас орлоо, наадмын өмнөхөн. Тийм ээ, энэ бол ингээд дэлхийн цаг уурын өөрчлөлт маань бидний амьдралд бол бодитоор ирчихлээ. Энэ бол нэг их тийм хол тэгээд л нэг ийм НҮБ хавьд байгаад л байдаг ийм шторк биш юм байна аа гэдгийг бол бид нар бүгдээрээ олж харлаа шүү дээ.

Тэгэхээрээ яг энэ агуулга руу байгаа. Тэгээд бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 30 хоногийн дотор боловсруулна. Засгийн газар бүрдсэнээс хойш. Боловсруулахдаа нэлээн тийм нарийвчилсан гэрээ хийнэ. Тэр гэрээ бол ойролцоогоор нэг 250-300 орчим хуудастай байна. Бүх асуудлуудыг нарийвчилж оруулна. Түүн дээр бид нар бүх улс төрийн намуудаас санал авна.

Тэгээд яг ногоон хөгжилтэй холбоотой асуудлаар бид нар Иргэний зориг ногоон намын байр суурийг сонгогчдын санал бол ногоон хөгжлийн төлөө өгсөн санал хэмээн үзэж, туйлын хүндэтгэлтэй ажиллая гэж хандах болно. Тэр юун дээр бас та бүхэн мөрийн



хөтөлбөрийнхөө саналуудыг нэмж бас тусгуулж болно гэдгийг бас танд хэлье.

Тэгээд тэр гэрээ хийгдчихвэл ер нь Засгийн газар ч бай, парламентын мэтгэлцээн ч бай, илүү тийм тодорхой бүтээлч болох магадлалтай юм байна лээ. Тэгэхлээр бусад улсын гэрээ бол яг тийм байдаг. Бид нар одоогийн байдлаар нэг 10 орчим улсын гэрээнүүдийг бэлдсэн байгаа. Та бүхэнд бас хэвлэж өгнө. Гэхдээ 30 хоногийн дараа. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Тодруулах уу? Батбаатар гишүүн тодруулъя.

**Б.Батбаатар:** Нөгөө сүүлд нь асуусан эрх зүйн асуудал, улс төрийн асуудал. Одоо 118 гишүүнтэй бүлэг байгуулагдаж байна гэж үзэх гээд байна шүү дээ. Нэг Засгийн газар дотор олонх, сөрөг хүчин, цөөнх гэж байдаг юм уу. Одоо улс төрийн намын даргын хувьд, Ерөнхий сайдын хувьд, ямар нэг эрх зүйн асуудал, Үндсэн хуулийн асуудлууд үүсээд ирвэл яах юм бэ? Би бол АН-ын бүлэг тун удахгүй татан буугдах юм байна л гэж харж байгаа юм. Засгийн газрыг сөрөг хүчний гэж яах вэ, аман хэллэг нь. УИХ дахь хуулиар бол цөөнхийн бүлэг гэж байдаг. Цөөнхийн бүлэг бол засгийг байгуулдаггүй. Олонхын бүлэг байгуулдаг.

Тэгэхээр энэ 2 бүлэг нэгдэх ажил хийгдэх юм байна. Энэ дээрээ юу гэж харж байгаа юм бэ л гэж.

**Ц.Сандаг-Очир:** Хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Мэдээж энэ бүлэг бол сонгуулийн үр дүнгээр байгуулагдчихаж байгаа. 126 гишүүнтэй энэ холимог тогтолцоо бүхий парламент анх удаа бүрдэж байна. Бид нарт шинэ тутам зүйлүүд байна. Энэ эвслийн болон хамтрах гэрээнээс авхуулаад. Ер нь зарчмын хувьд бол санал нэг. Аль нэг нам өөрөө төлөөллийн төв байгууллагаараа шийдвэр гаргачхаад байхад парламентад байгаа гишүүд нь

түүнийг дагаж хамт байх уу, үгүй юу гэдэг бол энэ бол улс төрийн зарчим. Тэгэхгүй нам нь оръё гэгчхээд, бүлгийн гишүүд нь яг хамтарч ийм зүйл хэрэгжүүлье гэгчхээд түүн дээр улс төрийн тоглолт хийгээд байвал тэр бол яах вэ, өмнөх 76-тай парламентад бол энэ байж болдог байсан л даа. Бүгдээрээ ингээд Засгийн газрынхаа эсрэг 1 намын хүмүүс хоорондоо хэрэлдээд л тэр нь гоё харагдаад л байдаг байсан. Одоо бол энэ чинь мэтгэлцээний парламент. Яг л үзэл санаагаараа л мэтгэлцэхгүй бол янз бүрийн юм яриад, эсвэл нөгөө хойноо байгаа ах нарынхаа захиа даалгаврыг биелүүлээд байвал тэгээд л ард түмэн тун удахгүй нэг нэгээр нь харна даа, энэ чинь. Тэгээд л дороо цээжилчихнэ, тийм болдог.

Тэгэхээр одоо энэ бол илүү тийм үзэл бодлын мэтгэлцээний парламент байгаасай билээ. Яагаад гэхээр хүлээлт өндөр байна. Тэр агуулгаараа та бол маш зарчмын зөв зүйлийг хандаж байгаа байхгүй юу. Тэр гэрээ хийе гэдэг ч гэсэн тэр.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Байнгын хорооны хуралдаан даргалагч, Байнгын хорооны гишүүд, Ерөнхий сайдын энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Надад 2 асуулт байгаа.

Бүхэлд нь мэдээж хэрэг бид яг зорилгодоо нийцсэн бүтэц тодорхойлох нь бол Ерөнхий сайдын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал. Энэ бүтцийг бол би бүхэлд нь бол дэмжиж байна. 2 зүйл дээр нэг нь бол яамны нэршилтэй холбоотой, нэг нь тэр нэршилтэй холбоотой бас нэг агуулгатай холбоотой нэг асуулт байна. Энэ жишээ нь нийгмийн харилцааны гол бүрэлдэхүүн хэсэг бол хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа байдаг. Засаглалын хэлбэр ямар байхаас үл шалтгаалаад, төрийн байгуулал ямар байхаас үл шалтгаалаад, нийгмийн

байгуулал ямар байхаас үл шалтгаалаад, хөдөлмөр гэсэн одоо жишээ нь тодотголтой төрийн захиргааны төв байгууллага байсаар ирсэн л дээ. Би бас гаднын улс орнуудыг ч гэсэн бас үзлээ. Заавал байгаад л байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр энэ хөдөлмөр гэдэг нь чиг үүргээр байж байгаа юм чинь яамныхаа нэршил дээр энэ хүн амын хөгжлийн, хүний хөгжлийн араас үүнийг тодотгоод оруулчихвал зохимжтой байгаагүй юу. Үүнийг ямар шийдлээр ингэж хийсэн юм бэ гэдэг асуулт байна.

2 дахь асуудал болохоор энэ хүн амын, хүний хөгжил үү, хүн амын хөгжил үү гэсэн бас нэг ийм ойлголтын бас нэг асуулт байгаад байна. Хүний хөгжил байх юм бол бид өөрсдөө мэдэж байгаа. Энэ чинь олон улсын хөгжлийн стратеги шүү дээ. Тийм ээ, НҮБ-аас тодорхойлж өгсөн их өргөн хүрээнд яригдана л даа. Тэгэхээр энэ боловсрол нь орж ирдэг, эрүүл мэнд нь орж ирдэг, эдийн засаг нь өөрөө орж ирээд орлогын асуудал эргэдэг. Нэг ийм л үзэл баримтлал. Энэ чинь Нобелийн шагнал авчихсан нь зүйл л дээ.

Харин бидний өнгөрсөн хугацаанд хэрэглэж заншсан энэ яах вэ, нэр томъёоны хувьд хүн амын буюу нөгөөх нь бол Фимийн Девелопмент нөгөөх нь Популэйшн Девелопмент шүү дээ.

Тэгэхээр хүн амын бүлгүүдийн гэдэг энэ хөгжлийн бодлогыг л жишээ нь энэ яам өөрөө чиг үүргийн хувьд бол хариуцаж байгаа юм. Тэгэхээр яах вэ, миний хувьд нөгөө том концепцийг нэрлэхээр зэрэг бүх юмаа оруулчихсан юм шиг болчих гээд байдаг. Тэгсэн нөгөө яг таныхаар тодорхойлох юм бол хүн амынхаар бол угаасаа чиг үүрэгт нь оруулчихсан л байна л даа. Түүгээр нэрлэхивэл зөв байгаа юу гэдэг нэг ийм 2 асуулт байгаа юм. Саяынхтай холбоод яах вэ, хүний хөгжлийг яах вэ, боловсролын түвшинд бас хэрэглэдэг л

дээ. Боловсрол дээр бол яг хүүхдийн хөгжлийн асуудал болгоод л ярьчихдаг юм. Гэхдээ бид үзэл баримтын түвшинд авч байгаа учраас энэ нэршлийг саяын хүн амын хөгжил үү, хүний хөгжил үү гэдэг дээр жишээ нь та бүхэн маань яаж бодсон бэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Ерөнхий сайд.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би бас түрүүн хэлсэн. Энэ нийгмийн хамгаалал, хөдөлмөр гээд ингээд салчихаар яг яаман дотор бол ингээд нийгмийн хамгааллынхан гээд нэг хэсэг, хөдөлмөрийнхөн гээд нэг хэсэг байгаа. Тэд нар бүгдээрээ нийлээд бид нар хүний хөгжлийн асуудал гэдгээ бол бараг хардаггүй.

Тэгээд сайд нь хөдөлмөр талын хүн очвол хөдөлмөр талаа бариад явчихдаг. Нийгмийн хамгаалал талын хүн очвол нийгмийн хамгаалал талаа бариад, эрэгтэй хүн очвол илүү хөдөлмөр талаа бариад, эмэгтэй хүн очихлоор илүү нийгмийн хамгаалалт талаа бариад ингээд яваад байдаг. Гэтэл бид нар бүхэлдээ энэ яам маань өөрөө яг үнэн, хүн ам гэхээр бас ерөнхий болчихоод байгаа юм. Хүн ам гэхээр яг хэнд хариуцаад ямар ажил хийх юм. Гэр бүл, яагаад гэвэл нийгмийн нэгж бол гэр бүл. Тэгээд гэр бүлийн асуудлаар яг манайх эрх зүйн энэ орчнууд ч гэсэн бас нэлээн илүү сайжрах ёстой. Гэр бүлийн орчин. Энэ нь өөрөө хүүхдийн хүмүүжилд маш их нөлөөлж байгаа. Энэ бол өөрөө Монгол Улсын ирээдүйн иргэнийг бэлдэж байгаа хамгийн анхан шатын нэгж бол өөрөө гэр бүл юм. Гэр бүлийн асуудлыг бид нар илүү их анхаарах ёстой. Энэ дээрээ хөдөлмөр, нийгмийн хамгаалал бүгд нийлж орох юм. Энэ нь өөрөө хүний хөгжил юм гэж хараасай л гэж хүсээд байгаа юм.

Бусад газар бол нийгмийн хамгаалал нь тусдаа эрхлэх сайдтай, хөдөлмөр нь тусдаа эрхлэх сайдтай л явж

байгаа шүү дээ. Сингапур эд нар бол бүгдээрээ тийм. Манайх шиг ингэж нөгөө нэг нийтлэг хариуцдаг. Ер нь яах вэ манай төрийн бүтцийн нэг алдаа бол хэт тийм ерөнхий явц. Тэгээд 1 ийм хэт ерөнхий юман дунд ерөнхийлсөөр байтал нэг жил өнгөрөөд л, дахиад 2 жил өнгөрөөд л ингээд л явчихдаг. Тэгэхээр ерөнхий чиг үүргүүдийг илүү зорилгыг нь тодотгоё л гэж байгаа юм.

Гэр бүл гэдэг энэ агуулга руу бид нар бүхэлдээ явуулж чадвал энэ дунд нийгмийн хамгаалал, хөдөлмөр бүх зүйл цогц ойлголт юм гэдгээ хараасай л гэж. Яах вэ, энэ дээр мэдээж хөдөлмөр зэрэг ийм үгүүдийг хэлэлцүүлгийн явцад парламентын гишүүд та бүхэн оруулж болно. Гэхдээ яах вэ, Засгийн газраас оруулж ирж байгаа бүтэц учраас энэ бол ингээд нөгөө салгаад ингээд явахаар бас яг ингээд гүйцэтгэх засаглал шиг яг бүтэн бас мэдээлэлтэйгээр оруулж ирнэ гэж бас хэцүү.

Тийм учраас энд тэнд байгаа юмнуудыг хамаагүй салгахгүй байхыг бас та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье. Тэгээд ажиллахгүй ийм бүтэц бас болгоод хаячихдаг. Одоо жишээлбэл Эдийн засгийн яам дээр явж байхад концессыг аваачиж булаацалдаад, нөгөө аль яамнаас аваад өгчихдөг билээ. Тэгээд хүртэл нөгөө нэг юунууд нь концепцийнх нь асуудлууд маргаантай. Уг нь бол Эдийн засгийн яам бодлогын л яам буюу Үндэсний хөгжлийн газар бий болсон. Гэтэл аваачаад тэнд надад концесс байх ёстой ч билүү нэг юм болоод тэгээд тэр нь худалдан авах ажиллагаа юу 2-ын дунд аваачаад яг төсөв хэлэлцэж байх үед эцсийн найруулга дээр гацаачихсан. Иймэрхүү бас зүйлүүд дээр парламентын гишүүд маань илүү хүндэтгэлтэй хандаасай л гэж хүсэж байна.

Тэгээд энэ бол эхлэл цэг. Бид нар төсвийн одоо 3 удаа төсөв хийгдэнэ. Тийм ээ, бүрэн эрхийн хүрээнд 4 удаа гэж болно. Тус бүр 10 хувиар ерөнхийдөө энэ бүтцийг илүү оновчтой болгоё гэдэг

ийм нийтлэг жишиг дээр улс төрийн намууд бас тохирсон байгаа.

Тийм учраас нэг үгээр хэлбэл бүтцийг илүү хооронд нь нөгөө нэг уялдуулах, төрийн албан хаагчдын заримынх нь ачаалал хэт их, зарим нь бага байгаа байдлыг тэнцвэржүүлэх ийм зүйлийг хийгдэнэ гэж ойлгож бол болно. Тэгэхээрээ үүнийг бид нар хамтдаа хийгээд явах ийм зүйл рүү эхлэхийн тулд энэ малгайг бүтцийг оруулж ирж концепцын хувьд ч гэсэн ойлголтыг оруулж ирж байгаа юм.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Тодруулах уу? Нэмж асуух уу, болсон уу? Нэмж асууя. Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Би яах вэ, Ерөнхий сайдын хэлж байгаа тэр гэр бүл гэж нэршлээр хэлж байгаад бол ерөөсөө түүнд санал нэг байгаа юм. Нийгмийн анхдагч бүтэц нь угаасаа гэр бүл. Нийгмийн суурь бүтэц нь бол гэр бүл гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Гэр бүлийн хөгжил бол нийгмийн хөгжлийн үндэс л гэж л ойлгож л байгаа юм л даа. Яах вэ, зүгээр миний асуугаад байгаа юм бол яг тэр гэр бүл хүн амын хөгжлийн араас таслал тавиад жишээ нь Хөдөлмөр гээд оруулчхаж болохоор байх л гэж ойлголоо л доо. Би өчигдөр оройжин л хайлт хийлээ.

Тэгээд болохоор Ливиз гэдэг улсад яг саяын энэ гэр бүл, хүний хөгжил, тэгээд жишээ нь уугуул иргэдийн гэсэн яам л байна л даа. Энэтхэгт яах вэ, Хүний хөгжлийн яам бол тусдаа байна гэдэг ч юм уу Энэтхэг бол манайхтай адилхан засаглалтай улс шүү дээ, парламентын засаглалтай. Тэгээд л яах вэ би зүгээр бодож байгаад араас нь таслал тавиад оруулчихвал чиг үүргийн дотор маш олон чиг үүрэг бол энэ яам дээр байгаа учраас тэгээд нэрлэхивэл гадагшаа харилцахад ч гэсэн амар болов уу л гэж бодож үүнийг зүгээр асууж байгаа юм.

**Ц.Сандаг-Очир:** Хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Тийм, энэ бол парламентын бүрэн эрх. Тийм. Тэгээд яах вэ, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар өөрөө ажиллаж байсан хүн үнэхээр яах вэ, хөдөлмөр гэдэг үг орох нь бол чухал гэдэг тийм агуулга байхыг үгүйсгэх аргагүй. Гэхдээ ингээд л нөгөө нэг салгаж л харчихаар цогцоор харах юм нь улам багасаад л тэгээд л нөгөө яам дотор байгаа газрууд чинь манай хөдөлмөрийн асуудал нийгмийн хамгаалалд ямар ч асуудалгүй ээ. Манай хүүхдийн асуудал залуучуудад ямар ч хамаагүй ээ гэж яваад байгаа нь, ер нь яах вэ, бүтцээсээ илүүтэй нөгөө манай төрийн албан хаагчдын маань ойлголт өөрөө интеграцад орох, ойлголт өөрөө цогц болох, салангид байгаа зүйлүүдээ олж харах гэдэг зүйл рүү л бас том реформ, сэтгэлгээний хувьд хийгдээсэй л гэж бас хүсэж байгаа юм.

Тэгээд түүнийг та хэд маань хэлэлцүүлгийнхээ явцад яриад ингээд явахад бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх хадгалагдана шүү дээ. Тийм.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Сайн байцгаана уу. Хэдийгээр Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалагддаггүй ч, Улсын Их Хурлын гишүүн нь харьяалаагүй Байнгын хорооны хуралд саналын эрхгүй оролцон асуулт асууж санал хураалгаж болно гэсэн эрхийн дагуу энэхүү Байнгын хорооны хуралдаанд оролцож хууль санаачлагчаас 2 асуулт асуух гэсэн юм.

1 дүгээрт, сая Зулпхар дэд сайд маань бид 2 сайд, дэд сайдаар ажиллаж байсан. Яг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай холбоотой асуудал. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны өмнөх чиг үүргээс залуучууд, эмэгтэйчүүд гэсэн үг л хасагдсан

болохоос биш чиг үүрэг нь яг хэвээрээ байгаа нь харагдлаа.

Тэгээд Гэр бүл, хүний хөгжлийн яам болгон өөрчилсөн байна. Манай улсын хувьд мэдээж хүн хөдөлмөр эрхлэлт маш чухал гэдгийг бүгдээрээ л бүх судалгаан дээр харагддаг.

Хөдөлмөрийн яам маань өөрөө энэ жил 65 жилийн түүхт ойгоо тэмдэглэж байгаа. 1959 онд Сайд нарын зөвлөлөөр анх Хөдөлмөр, цалин хөлсний товчоог байгуулж байсан.

Нөгөө талдаа мэдээж хүний хөгжлийн асуудал чухал. Иймээс ч Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого орсон. Өмнөх чиг үүрэгт ч байсан. Одоо ч гэсэн яг адилхан орсон байгаа. Иймээс зүгээр миний санал Эдийн засаг таслал хүний хөгжлийн яам болбол чиг үүрэгт нь байгаа ч, бас Шадар сайдын түвшинд хүний хөгжлийн асуудлаа чухалчлах боломжтой юм байна гэж харж, чиг үүрэгт өөрчлөлт ороогүй учраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг хэвээр нь үлдээх боломж байдаг болов уу гэдэг ийм зарчмын зөрөөтэй саналыг оруулж байна.

Ингээд хэрэвзээ миний энэ саналыг үндэслэлтэй гэж үзэх юм бол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.9-д заасны дагуу гишүүний албан бланк дээр бас зарчмын зөрөөтэй саналыг бэлдээд бас ирсэн байгаа. Санал хураалгаад, боломжтой үүн дээр бас анхаарал хандуулж өгөх боломжтой юу үгүй юу гэдгийг 1 дүгээрт, асууж байна.

2 дахь нь болохоор мэдээж анх удаа 32 эмэгтэй Улсын Их Хурлын гишүүнтэй болсон. Парламентын 25 хувийг бүрдүүлж байгаад бас Ерөнхий сайдад талархал дэвшүүлмээр байна. Бид үнэхээрийн Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийн өөрчлөлтүүдийг хийгээд эмэгтэйчүүдийн жендерийн энэ ялгаатай

байдлыг арилгах талд маш үр дүнтэй бодлогуудыг хэрэгжүүлж чадлаа.

Жендерийн хөгжлийн асуудал Ерөнхий сайдын эрхлэх хүрээний асуудалд ордог. Жендерийн үндэсний хороо маань албан статус байхгүй. Иймээс бүтэц дотроо төсвийн ямар нэгэн нэмэгдэлгүйгээр одоо байгаа төсөвтөө багтаагаад Засгийн газрын тохируулагч агентлагаар нэмэх боломжтой юу үгүй юу, албажуулах боломжтой юу, үгүй юу гэдэг 2 дахь асуудал байна. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Ариунзаяа сайд зарчмын зөрөөтэй санал гаргах эрх чинь бол нээлттэй. Энэ бол хэлэлцэх эсэх асуудал. Анхны хэлэлцүүлэг дээр зарчмын зөрөөтэй саналаа гаргах эрх чинь нээлттэй.

Асуултад хариулья.

**Л.Оюун-Эрдэнэ:** Нэршлийн хувьд яах вэ, миний хувьд санал нэг байна. Зүгээр Их Хурлын гишүүд та бүхэн маань ч гэсэн бас ингээд энэ агентлагууд ингэж данхайсан асуудал бол дандаа л яг саяынх шиг ийм санал хураалтууд шүү.

Тэгээд л яг төсвийн эцсийн хэлэлцүүлэг дээр аваачаад л ингээд л зүв зүгээр байгаа 2 агентлагийг аваачаад хооронд нь салгаад 1, 1 агентлаг байгуулаад л тэгээд л 1, 1 аймгаараа авчихдаг ч юм уу. Ингэсээр байгаад л ингээд л манай төрийн бүтэц өөрөө данхайсан.

Тийм учраас дахиж нэмж агентлаг эд нар байгуулах зүйлийг би бас Их Хурлаас хүсэхэд хэлэлцүүлгийн явцад ялангуяа Төсвийн байнгын хороо эд нар хяналт тавихгүй бол 126-уулаа агентлаг 1, 1-ээрээ ингэж байгуулбал энэ дийлдэхгүй юм болно шүү, дийлдэхгүй юм болно.

Тэгээд 1 хүний үзэмжээр жишээлбэл нэг агентлаг байгуулаад байвал тэгээд наадах чинь төрийн

байгууллагууд ажиллах боломжгүй болж гацах ийм зүйл үүснэ шүү. Тэгээд сайд байсан, парламентын гишүүн бас үүнийг мэдсээр байж ийм зүйл ярьж байгаад харамсаж байна.

Одоо бид нар илүү энэ чиг үүргүүдийг нэгтгэх тухай ойлголт руу явах ёстой. Шинэ 30 жил эхэлсэн гээд байгаа шүү дээ. Хэдүүлээ. Өмнө нь дандаа задлах тухай ингээд яриад явчихсан. Би бас ингээд нөгөө хамтарч ажиллах дээр ч гэсэн нэг хүсэж байгаа зүйл хэдүүлээ жил бүхэн 10 хувийг багасгаж явъя. Гэхдээ тэр нь нэг тийм бүдүүлэг байдлаар биш зүгээр л их өгөгдөлд тулгуурлаад би Учралд ч гэсэн бас хэлээд байгаа зүйл. Яг энэ чиг үүргүүдийн давхцалыг нь гаргачих, тэгээд алийг нь саарлаар алийг нь юугаар будаад тэгээд л түүн дээрээ хамгийн бага байгаа чиг үүргээ хамгийн их байгаа руугаа шилжүүлээд явъя.

Тэгэхгүй агентлаг хий байгуулагдсанаараа юм хийгддэг юм биш. Яг үнэндээ. Агентлаг. Зарим үед агентлаг байгуулагдсанаар ажил гацааж байгаа юм. Нөгөөдөх нь агентлаг бол төлөвших гэсээр байтал ингээд л нэг ийм юу болчихдог.

Тийм учраас энэ орон тоо бүтэц эд нар энэ агуулгаар бол битгий яригдаасай. Тэр нэршил болон философийн хувьд бол мэтгэлцээн болох нь зөв байх.

Залуучуудын асуудал бол бас Хүүхэд, гэр бүл, залуучуудын агентлаг гээд ингээд бас л байгуулчихсан. Тэгээд хүүхдийн асуудал, залуучуудын асуудал бол бас тусдаа асуудал шүү дээ. Ер нь бол. Хүүхэдтэй залуучууд тоглоод л байгаад байна гэхээс илүүтэйгээр залуучуудын хүсэл мөрөөдөл чинь илүү өөр зүйл байгаа. Тэгээд манай ихэнх чинь бас хүн амын бүтэц ч гэсэн залуучууд.

Тийм учраас яг залуучуудад хандсан тухайлсан ийм төрийн байгууллагын бодлогын чиг үүрэг бас

байхгүй болоод ирсэн. Залуучуудын холбоо гээд байгууллагыг маань бас нэг дотоод нөхцөл байдал нь бас нэг ийм сонин болчихсон тийм ээ, яг дотооддоо бас жоохон зөрчилтэй тэгээд 1 хэдэн байгууллагуудад залуучуудын холбоог түрээсэлдэг л нэг ийм хэмжээний л байгууллага болж хувирчхаад байгаа юм.

Тэгэхээр яг энэ залуучуудын энэ том том соёлын, спортын, мөн аялал жуулчлалын энэ агуулга, арга хэмжээнүүдийг тусад нь гаргах нь бол өөрөө илүү зөв байгаа юм.

Хүүхэд бол өөрөө зөвхөн хүүхэд гэж салахгүйгээр энэ бол гэр бүлийн асуудал байна. 18 насанд хүртэл бол тэр бол гэр бүл дотроо хүмүүжиж байгаа. 18 наснаас дээшээ бол тэр бие дааж байгаа. Бие дааж байгаа тэр олон одоо шинэ ирээдүйн Монголын хүний нөөц, мөн одоо ирээдүйн иргэдийн хувьд, хооронд нь бас бидний хувьд ингээд уулзаж, төр хоорондоо холбогдож бодлогоо тайлбарладаг байх энэ гүүр бас дутаад байгаа юм. Хүүхэд, гэр бүлийн юу гэхээр.

Тэгээд хүүхдийн асуудал яриад байдаг, хүүхдийн ч асуудалгүй, залуучуудын ч асуудалгүй болчихоод байгаа юм, одоо. Тийм учраас залуучуудын асуудлыг гаргаад, хүүхэд, гэр бүл гэдэг асуудлаараа явах нь бол зөв юм гэдэг энэ агуулга руу оруулж байгаа юм шүү.

Нэршил дээр тэгээд хөдөлмөрийг бол би санал нэг байна гээд байгаа шүү дээ. Гэхдээ гэр бүл гэдгээсээ манай эмэгтэй парламентын гишүүд өөрсдийн чинь л олон жилийн үзэл санаа шүү дээ. Үүнээс бас битгий ухраасай гэж.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Цогтгэрэл гишүүн байхгүй байна.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримттай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй үг

хэлж болно. Тэмүүжин гишүүн, Пүрэвдорж гишүүн, Доржханд гишүүн, Зулпхар гишүүн, Номинчимэг гишүүн, Болормаа гишүүн. Болормаа гишүүнээр тасаллаа. Батбаатар гишүүнийг нэмээрэй.

Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Засгийн газрын бүтэцтэй холбоотой тэгээд Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга байгаа 2, 2 хүн байгаатай холбоотойгоор нэг үг хэлэх гэж байгаа юм. Ер нь манай энэ өнгөрсөн 30 жил маш том алдаа гарсан. Түүний өмнөх 70 жилд бол угаасаа хууль тогтоох систем гэж байгаагүй. Тэгээд өнгөрсөн 30 жилийн хамгийн том алдаа юу вэ гэхээр уг нь Үндсэн хууль дээр хууль тогтоох эрх мэдэл гагцхүү УИХ-д хадгална гэж үгүй байж байгаа. Тодорхой нөхцөлд Засгийн газар руу хууль тогтоох эрх мэдлийн тодорхой хэсгийг хугацаатайгаар шилжүүлдэг тийм олон улсын жишиг байгаа юм.

Бид бол ямар нэгэн ийм стандартгүй, хязгааргүй, цаг хугацаагүйгээр Засгийн газар руу маш олон хэмжээний хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлсэн. Гадагшаа чиглэсэн хэм хэмжээ тогтоох эрх мэдлийг Засгийн газрын бүх түвшинд бараг эдэлж байгаа. Дэлхий нийтээрээ хуулийн засаглал тогтооё гэвэл нэг л зарчим байгаа. Тэр нь юу вэ гэхээр зөвхөн Засгийн газрын гишүүдэд хэм хэмжээ тогтоох эрхийг шилжүүлнэ. Агентлагууд болон өөр бусад субъектүүдэд хэм хэмжээ тогтоох эрхийг шилжүүлэхгүй гэдэг зарчим байгаа байхгүй юу. Манайх бол тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ер нь бүх агентлагууд гадагшаа ч гэсэн хэмжээ тогтоож байгаа. Өөрөөр бол хууль тогтоох эрх мэдлийг эдэлж байгаа. Үүнийг зогсоосон 4 жил байгаасай гэж би бол хувьдаа хүсэж байгаа, 1.

2-т нь, Засгийн газар руу шилжүүлэхдээ нөгөө улс орнууд чинь дахиад нэг цензур тавьж байгаа. Юу вэ гэхээр хууль зүйн нэгдсэн бодлогыг нь

барьж байгаа учраас зөвхөн Хууль зүйн сайд руу шилжүүлж байгаа шүү. Хэм хэмжээ тогтоох тэр статусыг.

Тэгээд Хууль зүйн сайдаас гадна өөр сайдуудад олгогдсон бол Засгийн газар дотроо энэ нь нөгөө хууль тогтоомжтой нийцэж байна уу гэдгийг ерөнхий хяналтыг Хууль зүйн сайд нь тавина шүү гэдэг эрх мэдлийг тэнд тодорхой болгож өгч байгаа байхгүй юу.

Тэгэхээр Хууль зүйн сайд хууль зүйн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх гэдэг энэ чиг үүргийг нь бас нэг сайн тодотгож өгөхгүй бол хуультай зөрчилдсөн, хуулиас давсан эрх хэмжээ олгогдоогүй байхад хэм хэмжээ тогтоосон маягтай зүйл бол газар авчихсан. Өмнөх Засгийн газрын үед бол Хууль зүйн сайд болон Ерөнхий сайд 2-уулаа хэлж байсан. Ер нь бол энэ нэг хуулиас гадуур хэм хэмжээ тогтоосон энэ нэг зүйлийг зогсооно гэдэг нэг ийм зарчим барьж байсан. Энэ зарчмынхаа төлөө бас ингээд тууштай үргэлжлүүлээд яваасай гэсэн тийм хүсэлтэй байна.

Нөгөөтээгүүр Улсын Их Хурлын дарга бас энэ дээр анхаарал тавиад Үндсэн хуулийн заалтыг нэг мөр бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоох байгууллага гадагшаа хэмжээ тогтоох эрх мэдлийг шилжүүлэхдээ хугацаатай, хязгаартай өгдөг байх зарчим руугаа шилжсэн нь дээр байх.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Би энэ Батбаатар дарга Ерөнхий сайдаас асуухдаа тэр нэг бүлэггүй болгох тухай л юм асуугаад байгаа юм. Тэгэхээр энэ бол 2004 онд МАХН, манай нам 2 нэгдээд Засгийн газар байгуулсан. Тэгээд байгуулахдаа 1 бүлэг байгуулаад ингээд явсан тэр л зүйлийг яриад байгаа юм.

Тэгэхээр Үндсэн хуулийн 39.2-т болохоор Монгол Улсын Ерөнхий сайдыг

томилохдоо олонхыг бүрдүүлсэн нам томилно. Аль эсвэл олон суудалтай нам бусад намаа уриад Ерөнхий сайдыг томилж болно. Аль эсвэл бусад тохиолдолд гэж байгаа юм. Тэгэхээр энэ удаагийнх бол МАН олонх болоод Ерөнхий сайдаа оруулж ирээд томилчихсон.

Тийм учраас энэ Улсын Их Хурлын тухай хуулийн 29.10 дээр сонгуулийн дараа Монгол Улсын Үндсэн хуулийн 39.2 дугаар хэсэгт заасны дагуу зөвшилцөн Засгийн газрыг байгуулахыг байгуулах олонхыг бүрдүүлсэн нам, эвсэл нь нэгэн бүрэн эрхийн хугацаанд эвслийн гэрээний дагуу 1 бүлэг байгуулна гэж байгаа юм. Тэгэхээр энэ чинь 2 дахь заалт нь байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл аль аль нь олонх бүрдүүлээгүй, олон болсон тэр нам Ерөнхий сайдаар томилсон тохиолдолд бүдүүн бүлэг байгуулах тухай асуудал байхгүй юу даа.

Тийм учраас ингээд үүнийг тэртээ тэргүй танд зөндөө олон хуульч нар байгаа. Ийм асуудлыг яриад л нэг тийм бүлэг байгуулахгүй, бүлгийг татан буулгах тухай асуудлыг бас нэг дахин дахин яриад байгаад гайхаж байна. Тийм учраас энэ дээр тодорхой тайлбар өгье гэж бодлоо. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр энэ асуудлыг бол дэмжиж байгаа. Тэгээд бид нар ХҮН намын хувьд бол аль болох төрийг цомхон байлгах ёстой, мэргэжлийн байлгах ёстой, ур чадвартай байлгах ёстой, мерит зарчим дээр суурилсан байх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгээд тэр ч агуулгаараа энэ удаагийн Засгийн газрын бүрэлдэхүүн дээр бол яамдын тоог нэмэхгүйгээр оруулж ирж байгаа. Тэгээд цаашдаа бас 30 хоногийн хугацаанд бид нар үйл

ажиллагааныхаа хөтөлбөрийг, тэгээд түүнд тохирсон бас энэ цомхон чадварлаг ийм бүтцийг оруулж ирнэ гэсэн ийм ерөнхий бас ойлголттой хүлээлтэй байгаа гэдгээ нэг хэлчихмээр байна.

Тэгээд редакцын нэг жижигхэн засвар байна. Манай ажлын хэсгийнхэн анхаараад явчихна биз. Энэ хуулийн 3.20.3 дээр худалдаа гэдэг үг оруулах ёстой байх. Тэгэхээр гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын болон бүртгэлийн асуудал гэдэг энэ нэг редакцын завсрыг оруулаарай гэж хүсэж байгаа юм. Тийм. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Аль хуулиа хэлж байна, та?

**Т.Доржханд:** Засгийн газрын бүрэлдэхүүний тухай Монгол Улсын хуулийн 3.20.5 дахь хэсгийн 3 дахь заалт байгаа.

**Ц.Сандаг-Очир:** Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Иргэний зориг ногоон нам бол өөрийн гэсэн байр суурь, улс төрийн байр сууриа гаргасан. Бид нар сонгуулийн маргааш хуралдаад Иргэний зориг ногоон нам ямар нэг байдлаар Засгийн газарт орох тухай саналыг олонх болсон намд хүргүүлэхгүй, ярихгүй, бид сөрөг хүчний үүргийг сонгуулийн хугацаанд гүйцэтгэнэ гэж иргэд, сонгогчдод амлаж байсан. Тэр байр суурин дээрээ байна гэдэг ийм улс төрийн зөвлөлийн тогтоол шийдвэр албан ёсоор гаргачихсан байсан. 6 сарын 29-ний өдөр.

Тэгэхээр өнөөдөр энэ хуульд байгаа Засгийн газрыг хэрхэн бүрдүүлэх юм, Сонгуулийн дараа гэдэг энэ хуулийн зүйл, заалтыг улс төрийн шийдвэр гаргаж байж, хуульд оруулсан шүү дээ. Их Хурлын гишүүд кнопоо үнэлж, засагт ордог. Их Хурлын бүлэг дотроос тодорхой гишүүд нь сайд болохын тулд

гишүүнээсээ, юу намынхаа харьяаллаа өөрчилдөг, шинээр нам байгуулдаг. Нэг ёсондоо иргэд сонгогчдын өгсөн саналыг Засгийн газрын сайд байдаг юм уу, бялуу гэж энгийнээр ярьдаг. Тэр зүйлийг авахын төлөө ашиглах тэр ашиглана, одоо шамшигдуулах гэдэг бараг энгийнээр ярьдаг шиг ийм нөхцөл байдлыг үүсгэхгүйн тулд хуулийг өөрчилсөн.

Тэгэхээр УИХ дахь АН-ын бүлэг бол Засгийн газарт хамтарч байгаагаараа сөрөг хүчин, цөөнх гэдэг зүйлээс татгалзаж, Улсын Их Хурлын тэр бүлгийн статусаасаа гарах хэрэгтэй. Энэ бол эрх зүйн ойлголт, улс төрийн ойлголт. Энэ Засгийн газрын тухай Үндсэн хуульд орсон энэ Их Хурлын тухай энэ олонхоос Ерөнхий сайд томилно. Энэ бүх зүйл чинь дандаа улс төрийн шийдвэрээр хуульд орсон өөрчлөлт. Улс төр нь ингээд болохгүй байгаа учраас кноп зардаг ийм зүйлийг больё гэж оруулсан. 2005 онд АТГ-ын даргыг батлах хуулийн төсөл орж ирэхэд 31, 30 гэдэг тоогоор санал хураалтын дүн гарсан шүү дээ. Ерөнхийлөгч санал оруулж АТГ-ын даргыг томилно гэхэд 31 болоод тэр нь ялчихсан. Нэрийг нь уншсан чинь Ардын намынхан Ерөнхийлөгч талд, Эх орон-ардчилал эвслийнхэн нөгөө талд өгсөн. Эрдэнэбүрэн гишүүн нөгөө талд ганцаараа өгчихсөн байсан. Би зэрэгцэж сууж байгаад асуусан. Яаж байгаа юм бэ? Үгүй ээ, танай АН-ынхан миний нэг кнопыг үнэлэхгүй байна шүү дээ л гэж хэлсэн шүү дээ. Кнопоо үнэлүүлмээр байна л гэсэн. Түүнээс хойш хэд хэдэн Засгийн газар огцорсон. Дандаа кнопоо үнэлсэн шүү дээ, Их Хурлын гишүүд. Байр суурь зарчим барьж чадаагүй шүү дээ. Шуналаа дийлээгүй шүү дээ. Одоо тэр лүүгээ орох гээд байна гэсэн үүднээс тогтвортой удаан хугацаанд хөгжлийн төлөөх Засгийн газар байгуулагдахын тулд олонхоо бүрдүүл гэж яриад байгаа юм. Засгийн газрын төлөөх. Засаг барих эрхийнхээ төлөөх.



Засаг барих эрхийнхээ төлөөх олонхыг бүрдүүлж байгаа бол УИХ цөөнх болж жүжиг тавиад хэрэггүй ээ гэж байгаа юм. Ерөнхий сайдтайгаа хамтраад нэг баг болоод ажиллах ёстой шүү дээ. Энэ бол зарчмын л асуудал шүү дээ. Улс төрийн асуудал. Эрх зүйн асуудал. Үндэс язгуурын тухай асуудал шүү дээ. Гомдоод л нэг их буруу ойлгож байна гээд л нэг аргаа барсан тал еэвэнгийн онигоо яриад хэрэггүй.

**Ц.Сандаг-Очир:** Гишүүдэд нэг зүйлийг анхааруулья. Энэ зөвхөн хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй үгээ хэлнэ. Үүнийг та бүхэн дэгээ бариарай гэж хэлье. Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Ерөнхий сайдын оруулж ирж байгаа Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийг бүхэлд нь бол дэмжиж байна. Ер нь бол яах вэ, бид зорилгодоо нийцсэн бүтэцтэй байх ёстой гэдэг энэ онолыг ч бай, энэ арга зүйг угаасаа өнгөрсөн хугацаанд эдэлж байсан. Цаашаа ч гэсэн энэнээс бол нэг их тийм бид гажиж чадахгүй. Үүнээс өөр арга одоохондоо олдоогүй байгаа учраас энэ хамгийн чухал гэж байгаа юм.

2 дугаарт, Ерөнхий сайдын саяын хэлсэн гэр бүлийн тухай яам байгуулах асуудал бол их чухал байсан гэж. Энэ үнэн. Энэ 16 онд ч бай, 20 онд ч бай энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг ярьж байх үед бол энэ бол МАН-аас гарч байсан санал, эмэгтэйчүүдээс гарч байсан санал. Нийгмийн суурь бүтэц дээр бид анхаарахгүй бол болохоо байлаа. Энэ бол хөгжлийн суурь гэж байсан учраас би үүнийг сайшааж байна, чухал гэж үзэж байна. Таны тайлбарыг бол би бас ойлгож байна. Хүний хөгжил дотроо бол бүгд байгаа учраас болно гэдэг. Үүнийг ч гэсэн би бол хүлээж авч байна.

Гэхдээ яах вэ, нөгөө 4 жил бас дотор нь байсан учраас туршлага бол байна. Гаднын байгууллагуудтай харилцах, гаднын адил төстэй төрийн

захиргааны төв байгууллагатай харилцахад яг хөдөлмөрийн чиглэлээр энэ тодотгоод оруулчихсан байхад илүү бас харилцаан дээр бидэнд бол ач холбогдолтой байх байх гэж бодож байгаа юм. Би саяхан АНУ-ын Хөдөлмөрийн дэд сайдтай очиж хэлэлцээр байгуулчхаад байсан шүү дээ. Анх удаа болсон юм. Ингэж байж энэ хэлэлцээр бол их өндөр түвшинд хүрдэг юм байна гэдгийг бүр ойлголт авсан олон улсын хөдөлмөрийн байгууллага байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын төрөлжсөн байгууллага шүү дээ. Яг энд бид өөрийн гэсэн мандаттай, энэ хүрээнд байнга байнга хаачилцдаг байх.

3 дугаарт, бид чинь нөгөө хөдөлмөр, нийгмийн 3 талт үндэсний хэлэлцээр байгуулдаг. Ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлийн төлөөлөлтэй. Энэ дээр бол хөдөлмөр нь өөрөө их голлодог учраас үүнийг би бас чухалчлаасай гэж бодож байна. Засгийн газрын бодлого ч гэсэн энэ хөдөлмөртэй холбоотой зүйл дээр бол их чухалчилж байгаа учраас ингээд л тодотгочихвол болох болов уу гэсэн миний зүгээр санал байна.

2 жижиг бас санал байна. Жижиг биш боловч энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний ны тухай хууль дээр сайд нарын жишээ нь чиг үүргийг тодорхойлсон байгаа. Түүн дээр би хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцсан сайдын хувьд энэ хөдөлмөрийн нөхцөлийн араас хөдөлмөрийн аюулгүй байдал гэдгийг оруулж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. 2,1 сая хөдөлмөрийн ёсны хүн амын гол үндсэн асуудал учраас үүнийг оруулчхаач ээ гэсэн нэг санал байна. Энэ 15 дээр байгаа нь, 15.

14 дээр бас энэ Боловсролын сайдын чиг үүрэг дээр Боловсролын сайд болохоор зэргийн болон мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах асуудал гээд нэмчихвэл яасан юм бэ гэж байгаа юм. Сая Ерөнхий сайд

өөрөө ч гэсэн бас үүнийг яриандаа бол их тодотголоо шүү дээ. Үүнийг зэргийн болон мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах гэж их тодорхой оруулж өгмөөр байна. Бид бол судалгаагаа хийчихсэн. Одоо энд хөдөлмөрийн зах зээлийн уялдааг л хангана гэдэг бол бидний гол зорилт байгаа шүү дээ. Хөтөлбөрүүд чинь энэтэй уялдсан байх ёстой, тэгж байж хүн бэлтгэгдсэн байх ёстой, тэгж байж хүмүүс ажилтай болдог, тэгж байж хөдөлмөрийн зах зээл өөрөө үр дүнтэй ажилладаг. Гаднаас болон дотроос ажиллах хүчнүүд зөв зохицуулалт хэлбэр лүү орно гээд. Ийм 2 зүйлийг нэмээд нэмээд өгөөч ээ гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа.  
Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Баярлалаа.  
Өнөөдөр оруулж ирсэн асуудлаас Ерөнхий сайдын оруулж ирсэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг бүхэлд нь дэмжиж байна. Зүгээр энэ дээр бас нэг 2 санал хэлээд дараа дараагийн бас хэлэлцүүлгийн шатад үүнийг бас хэлэлцээд явах байх гэж бодож байна.

1 дүгээрт, энд нэршлийн тухай бас ярьж байна. Түрүүн ХЗДХЯ дээр шударга ёс гээд энэ нөгөө minister of justice гэдэг гаднын англи хэл дээрх энэ үгийг бас ингээд орчууллаа гээд орж ирж байх шиг байна. Гэхдээ яах вэ, Тэмүүжин гишүүн хэлж байна л даа. Энэ нөгөө прокурортой, хяналттай энэ системүүдэд л жастис гэдэг үгийг хэлдэг гээд. Энэ бас үгүй юм. Яг манай Монгол шиг эх газрын эрх зүйн тийм ээ, Япон байна, Франц байна, Хятад байна, прокурорын чиг үүрэг нь аторный женерал байхгүй ийм системүүд ч гэсэн Хууль зүйн яамаа англи хэл дээр бол minister of justice гэдэг. justice гэдэг үг бол нөгөө Ло гэдэг үг өөрөө Монгол хэл дээр нэг бол хууль, нэг бол эрх зүй гэж бууж байгаа шиг жастис гэдэг үг бол өөрөө мэдээж шударга ёс гэсэн үг байгаа.

2 дугаарт, нэгэн улсын хуулийн систем, бүтэн систем тийм ээ, нэгдсэн хуулийн бодлого систем гэсэн ийм бас агуулга байдаг юм. 2 утгатай. Тэгэхээр яах вэ, энэ дээр бас шударга ёс тогтоох асуудал бол зөвхөн нэг яам гэхээсээ илүү Засгийн газар, Улсын Их Хурал, манай төрийн байгууллагын бүхий л байгууллагуудын эрхэм чиг үүрэг байх ёстой байх.

Тийм учраас ХЗДХЯ-аараа байвал яасан юм бэ гэсэн ийм нэг саналтай байна.

2 дугаар санал бол энэ Улсын Их Хурал бол бас эдийн засаг, энэ бас томоохон реформуудыг хийсэн 4 жил Улсын Их Хурал байгаасай гэж хүсэж байгаа. Түүний нэг юм Газрын багц хууль байгаа. Тэгээд өмнөх Улсын Их Хурлын үед Газрын багц хууль ороод нэлээн хэлэлцэгдэж байгаад тэгээд татагдсан. Газрын багц хуулийн хамгийн тулгамдаж байгаа бид нар бас ийм системийн хувьд хийх ёстой нэг асуудал бол бүртгэлийн асуудал байдаг. Эд хөрөнгийн бүртгэлийн асуудал, газрын кадастрын асуудал 2 өөр газар байдаг учраас бүртгэл нэгдэж чадахгүй, нэг дамжсан системээр яваад түүн дээр алдаа мадаг гардаг учраас энд иргэд, ААН-үүд маш их хохирдог.

Тэгээд ер нь бол бид ингээд тусдаа ийм бүртгэлтэй биш нэгдсэн системтэй байж байж газрын асуудлаа цэгцэлнэ. Тэгээд яагаад энэ ингээд хийгдэж чадахгүй байна аа гэхээр эд хөрөнгийн бүртгэл нь Хууль зүйн яам дээр, кадастр нь хуучин нөгөө геодез бас өөр яамны харьяа байсан. Ингээд ингээд хоорондоо ингээд яадаг аа гээд ийм асуудал байдаг.

Тэгэхээр бид бас ингээд цааш цаашдын хийх реформоо бодоод энэ бүртгэлийн асуудлыг бас бүхэлд нь хараад, зөвхөн нэг яамны харьяа гэхээсээ илүү салбар дундын зохицуулалттай нэгтгэж чадах энэ газраа бүртгэлийн асуудлаа нэгтгэвэл яасан юм бэ? Үүнийг

бас цаашид бид хэлэлцүүлгийн явцад хэлэлцээд саналаа гаргаад явъя гэж бодож байна. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа.  
Болормаа гишүүн.

**Э.Болормаа:** Сайн байцгаана уу. Бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн оруулж ирж байгаа хуультай холбоотой 3 саналыг хэлье.

Юуны өмнө байгаль орчны асуудал дээр уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг нэмсэнд нь их талархалтай байна. Ер нь бол би Батбаатар гишүүнтэй үүн дээр санал зөрөлдөж байгаа. Манайх бол ногоон хөгжлийн асуудлаараа улам сайжирч явж байгаа гэж харагдаж байгаа. Урт хугацааны хөгжлийн бодлогодоо ч тэр, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртөө ч тэр, энэ асуудлыг нэлээн сайн оруулж ирж байгаа. Харин зүгээр дэлхийн чиг хандлага өөрөө ногоон хөгжил гэдгээс холдоод ногоон эдийн засаг руу орж байгаа байгаа.

Тийм учраас бас сая Ерөнхий сайдын хэлсэн энэ маань салбар дамнасан асуудал гэдгийг хэллээ. Тэгэхээр магадгүй энэ дээр редакцын асуудал юм болов уу. Энэ Засгийн газрын тухай хуульдаа үүнийг Эдийн засгийн хөгжлийн яамныхаа бас харьяа ногоон хөгжил гэдэг бол хөгжлийн бодлого, иргэдийн амьдралын чанар, мөн өөрөө эдийн засгийн асуудал учир үүнийгээ яг хариуцсан хэсэг дээрээ ажлын хэсгийнхэн маань эдийн засгийн хөгжил рүүгээ оруулах нь илүү зүйтэй болов уу. Тэр ч утга агуулгаар бас Ерөнхий сайд сая хэлсэн болов уу гэж харж байна.

Үүнээс гадна уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор саяын бидний хэрэгжүүлсэн энэ Шинэ хоршоо хөтөлбөр маань өөрөө тэр чигээрээ уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицохтой холбоотой асуудал учир энэ маань цаашдаа хаашаа орох вэ? Хүнс, хөдөө аж ахуйн яам дээрээ юу эсвэл магадгүй уур

амьсгалын өөрчлөлт гээд оруулж ирсэн учир ийшээ чиглэх үү гэдэг дээр та бүхэн бас санал дээр бодож үзээрэй гэж хүсмээр байна.

Тэгээд редакцын 2 дахь нэг асуудлыг нэмж хэлэхэд үзэл баримтлал дээр онцгойлон байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгана гэсэн байна. Байгаль орчны сөрөг нөлөөлөл багасгана гэхгүй байх. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгийнхэн анхаарч өгнө үү гэж хүсье.

2 дахь асуудал дээр би энэ хөдөлмөрийн асуудал болон төрийн албаны тухай энэ асуудал дээр нэг саналыг хэлье гэж бодож байна. Яагаад гэвэл бид нар нэршлийн тухай л яриад байх шиг байна гэж бодож байна. Нэршил дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж бид маш удаан явсан. Энэ маань асуудал хэвээрээ байгаад байгаа учир нэг удаа нэршил солих тийм том асуудал болов уу гэж бодохгүй байна. Гаднын нэг байгууллагатай хөдөлмөр гэдэг утгаар уулзах бол нэг их тийм чухал асуудал биш. Хөдөлмөрийнхөө асуудлыг эрхэлсэн яам, сайд л юм чинь тэр хэвээрээ. Харин магадгүй цаашдаа үүнээс зоригтойгоор энэ хөдөлмөрийн асуудлаа энэ хүний хөгжлийн яамнаасаа холдуулаад магадгүй эдийн засаг эсвэл Боловсролын яамтайгаа илүү ойрхон байх нь энэ том зургаараа хөдөлмөрийн бодлогоо бид нар нэгдсэн байдлаар авч явах ёстой болов уу гэж бодож байна.

Бид нар зөвхөн төрийн албаны цомхон байдлыг яриад байгаа боловч энэ том зургаараа хөдөлмөрийн бодлогын зөвхөн нэг хэсэг нь. Төрийн албанаасаа тэгвэл сая Доржханд гишүүн ярилаа. Тийм ээ, цомхотгосон бүтэц оруулж ирнэ гэвэл тэгвэл цомхотгосон хүмүүс маань хаашаа явах юм. Хөдөлмөрийн зах зээлийнхээ хаана байх юм гэдгийг эдгээр асуудлыг бид нар том томоор нь харах ёстой болов уу гэж хэлмээр байна.

Тэгээд миний 3 дахь санал энэтэй бас дахин холбоотойгоор цаашдаа хийх зорилтуудын, өөрчлөлтүүдийн саналуудыг бас хууль санаачлагч Ерөнхий сайд хэллээ. Энэ ажлын хэсэг маань энэ дээр бас цаг алдалгүй ороосой гэж чин сэтгэлээсээ хүсмээр байна. Тэгэхгүй бол Засгийн газар бүрэлдээд бүгдээрээ яам яам дээрээ очоод, тэгээд түүндээ тухтай болоод л яг энэ ярьж байгаа өнөөдрийн өөрчлөлтүүдээ, цаашдын зориглож байгаа өөрчлөлтүүдээ хийхгүй байх вий гэдэг ийм бодол байна.

Тийм учраас цаг алдалгүй дараагийн өөрчлөлтүүдээ ч гэсэн ялангуяа энэ хөдөлмөрийн зах зээлийн төрийн албаны шинэчлэл өөрчлөлтийн асуудлуудаа цаг алдалгүй ороосой тэгээд энэ саналыг тэр чигээр нь дэмжиж байна. Ялангуяа бүтцийг томсгоогүй, яг ийм боломжийн хэмжээнд нь авч үлдсэнийг нь бас онцгойлон дэмжиж байгаагаа хэлье. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Ерөнхий сайд Оюунэрдэнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Гишүүд та бүхний хэлсэн зүйлүүдийг маш сайн тэмдэглэж авлаа. Тэгээд мэдээж би бас хэлсэн. Энэ бол Улсын Их Хурлын гишүүдийн хуулиар олгогдсон бүрэн эрх. Засгийн газар Ерөнхий сайдын хувьд өөрийнхөө л үзэл баримтлалын дагуу оруулж ирж байгаа. Энэ дээр ЗГХЭГ болон бусад эдийн засгийн яамнууд бас ажилласан байгаа гэсэн үг.

Тэгэхээр нэршлийн хувьд үнэхээр хөдөлмөр гэдэг үг зайлшгүй хэрэгтэй бол үүнийг бол бид нар ойлгож байна. Зүгээр урт л болох байх. Гол агуулга бол нэршлээсээ болж битгий яам дотор чиг үүргүүд болон цогцоор ажиллах ийм боломжоо битгий алдаасай л гэдэг л ийм агуулга байгаа юм.

Хүний хөгжил, гэр бүл гэдэг тал руугаа нийгмийн хамгаалал нь ч тэр, нийгмийн даатгал нь ч тэр, хүүхэд гэр

бүлийн залуучуудын агентлаг нь ч тэр бүгд хамтдаа ажиллаасай. Тэгэхгүй ингээд хоорондоо салчхаад, тэгээд нөгөө нэгдсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаад л дүгнэлт хийж байгаа юм шүү.

Тэгэхээр энэ бол байж болно.

ХЗДХЯ хэвээрээ үлдэж болно. Гэхдээ түрүүн яг Тэмүүжин гишүүний хэлдэг, бас Номинчимэг гишүүний хэлж байгаа ч гэсэн. Одоо бид нар яг энэ хууль зүй, шударга ёстой холбоотой аль нь яг шүүх дээр юу болоод байгаа юм, яг ХЗДХЯ ямар чиг үүрэгтэй юм, прокурор гэж яг ямар чиг үүрэгтэй юм гэдгийг олон нийтэд ойлгуулахгүй бол энэ дунд нэг үгээр хэлбэл маш их тийм будилаан гардаг. Гэнэт ингээд л нэг юм болчихдог. Тэгээд одоо та бүхэн парламент дотор орж ирээд ойлгоно. Жишээлбэл яг нэг зүйл болж байгаа нь дандаа шүүхтэй холбоотой нэг юм.

Парламентаар шийдэх болохоор л нэг сенсацтай ийм нийгэм заавал болдог. Одоо би бол үүнийг бүр сайн мэдэрдэг болчихоод байгаа юм. Гэхдээ одоо бол бас аргыг нь ойлгодог болчихоод байгаа юм. Тэгээд л бужигнаан болно. Бужигнаан болох хоорондуур манай гишүүдийг лоббидчихно. Ингээд л авлигын эсрэг шүүх бол буруу юм гээд л хэдэн хүмүүс хэлээд л, тэгээд л байхгүй болгочихно. Ингээд мартчихна. Ийм агуулгууд их гардаг шүү.

Шүүх дотор жишээлбэл тэр Батдэлгэр гэж нэг нөхрөөс авхуулаад л олон олон хүмүүс дандаа ийм будилаан тарьдаг. Одоо шүүгч нар бас энэ ордон дотор амьдардгаа болимоор байгаа юм. Гишүүдийн арын өрөөнд л ингээд л байж байдгаа бас болих хэрэгтэй. Шүүх засаглал шүүх засаглалаараа л баймаар байгаа юм. Би бас хэлэхэд шүүхэд шүүмжлэлтэй хандаж байгаа зүйл байгаа. Гэхдээ би хэзээ ч хэн нэг шүүгчтэй тусгайлан Ерөнхий сайдаар томилогдсоноос хойш нэг ч удаа уулзаж байгаагүй. Энэ протоколтой байхтай байх

ёстой. Энэ өөрөө эрх мэдлийн салангид байх зарчим шүү.

Тийм учраас үүнийг бас хийхийн тулд энэ шударга ёс гэдэг үг энэ идеологийг бас оруулж ирэх нь зүйтэй юм шүү гэж үзсэн. Шүүх ч гэсэн өөрөө шударга ёсны ордон гэж хийх хэрэгтэй. Тэрийг үүнийг ингээд л Ерөнхий сайд яриад л, тэгээд л тэр нь зөв буруугаараа дуудуулаад явж байх биш тэр чиг үүргийн байгууллагууд өөрсдөө ажлаа хийх хэрэгтэй. Яагаад гэхээр 70 хувь нь нийгэм шударга биш байна аа гээд нийгмийн дүгнэлт гарчхаад байхад яагаад тэд нар энд санаа зовохгүй байгаа юм. Энэ агуулгыг бас бид нар ярих ёстой шүү. Хүн харахгүйгээр бид нар тогтолцооных нь хувьд харах нь бол зүйтэй шүү гэж бодож энэ агуулгыг бас оруулж ирсэн юм.

Дээрээс нь 30 хоногийн дотор бид нар Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. Засгийн газар бүрдсэнээс хойш. Ингээд 30 хоногийн дотор төлөвлөгөө, хамтын ажиллагааны санамж бичиг буюу гэрээтэй яг олон улсын хамтарч байгаа Засгийн газрын түвшинд оруулж ирнэ. Энэ дээр бид нар Герман болон Шинэ Зеландын яг энэ сонгодог парламентын засаглалтай хувь тэнцүүлсэн тогтолцоотой энэ улс орнуудын нийтлэг жишгийг барина. Энэ гэрээ хийгдсэнээр тухайн гэрээнд тусгагдсан зүйлүүд дээр л бүлгүүд хамтарч тухайн асуудлаа шийдэх ийм үүрэг хүлээнэ. Ийм чөлөөтэй асуудал гэхээс илүүтэйгээр гэрээний 1.3.4 дээр орон сууцын газрыг Богд уулын ард чөлөөлнө гэсэн тийм учраас хамтдаа байна гэдэг агуулга руу явна. Тэгэхгүй ингээд ерөнхий яриад яваад байхаар хайран цаг болдог.

Тэгэхээр 30 хоногийн дараа бас тэр гэрээн дээр хэдүүлээ хамтдаа сууцгаая. Намууд бас аль аль нь бас ажлын хэсэг дээр хүмүүс гаргаж өгөх байх. Тэгээд маш тийм нарийвчилж сууж чадвал энэ бол өөрөө улс орны цаашдын

амьдралд тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд.

Нөгөө талаараа улс төрийн соёл тогтоход маш их тийм чухал зүйл бас болно гэж бас бодож байна.

2025 оны төсвийг бид нар оны эцэст оруулж ирнэ, тийм ээ. Одоо 9, 10 сард боловсруулна. Түүн дээр яг өнөөдрийн энэ бүтцээр уялдаад агентлагуудын чиг үүргийг дэлгэх биш, агентлагуудын чиг үүргийг илүү хумина. Энэ дээр бас улс төрийн дэмжлэгийг та бүхэн бас үзүүлэхийг хүсье.

**Ц.Сандаг-Очир:** Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримттай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя.

Дэгийн хуулийн 35.11-ээр энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасан байна.

Тийм учраас өргөн барьсан хуулийн төслүүдийг тус бүрээр нь санал хураалт явуулах юм байна. Санал хураалтыг илээр гар өргөж явуулна.

Хуралдааны ирцэд 20 гишүүн байна. Санал хураалт явуулж эхэлье.

Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

20 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж дэмжлээ.

2. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

20-оос 17 дэмжигдлээ.

3. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17 дэмжигдлээ.

4. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

20-оос 17 дэмжигдлээ.

5. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17 дэмжигдлээ.

6. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17 дэмжигдлээ.

7. Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

8. Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь

зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

20-оос 17 дэмжигдлээ.

9. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17 дэмжигдлээ.

10. Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17 дэмжигдлээ.

11. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

12. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

13. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

14. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

15. Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

16. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

17. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 17.

19. Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 16.

20. Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 16.

21. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 16.

22. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 16.

Санал хураалт явагдаж дууслаа.

Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан 3 асуудлаа хэлэлцэж дууслаа.

Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*П.ОЮУНГЭРЭЛ*